

# 2019

Ард Санхүүгийн Нэгдэл

## ЖИЛИЙН ТАЙЛАН

---

**Хөрөнгө  
Оруулагч  
Үндэстэнг  
цогцлооно**



# Агуулга

|           |                                                  |
|-----------|--------------------------------------------------|
| <b>4</b>  | <b>Гүйцэтгэх удирдлагын тайлан</b>               |
| <b>12</b> | <b>2019 он тоогоор</b>                           |
| 14        | Санхүүгийн харьцаа үзүүлэлт                      |
| 15        | Нэгтгэсэн үзүүлэлт                               |
| <b>16</b> | <b>Компанийн тухай</b>                           |
| <b>18</b> | <b>2019 оны онцлох үйл явдал</b>                 |
| <b>20</b> | <b>Хувьцаа эзэмшигчдийн бүтэц</b>                |
| <b>21</b> | <b>Төлөөлөн Удирдах Зөвлөл</b>                   |
|           | ТУЗ-ийн дарга                                    |
|           | Ердийн гишүүд                                    |
|           | Хараат бус гишүүд                                |
| <b>32</b> | <b>Гүйцэтгэх удирдлагын баг</b>                  |
| <b>36</b> | <b>Охин компаниудын удирдлага</b>                |
| <b>38</b> | <b>Эдийн засгийн орчин</b>                       |
| 39        | Мөнгө, санхүү                                    |
| 40        | Хөрөнгийн зах зээл                               |
| 41        | Валютын зах зээл                                 |
| <b>42</b> | <b>Гүйцэтгэлийн тайлан</b>                       |
| 42        | Үйл ажиллагааны гүйцэтгэл                        |
| 44        | Маркетинг                                        |
| 46        | Хүний нөөц                                       |
| 48        | Технологи                                        |
| 49        | Хөрөнгө оруулалт                                 |
| 51        | Санхүүгийн гүйцэтгэл                             |
| <b>54</b> | <b>Хөрөнгө оруулалтын багц</b>                   |
| <b>69</b> | <b>Бидний ойрын ирээдүй</b>                      |
| <b>70</b> | <b>Үнэлгээ</b>                                   |
| <b>71</b> | <b>Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны арилжаа</b> |
| <b>72</b> | <b>Хараат бус аудитын тайлан</b>                 |

# Гүйцэтгэх удирдлагын тайлан

## Хүндэт хувьцаа эзэмшигчид ээ!

Жил болгоны хавар бид та бүхэндээ өнгөрсөн онд хийж бүтээсэн ажлаа дэлгэн танилцуулж, гаргасан амжилтаа хуваалцдаг уламжлалтай билээ. Энэ удаад бид тайлангаа анх удаагаа зөвхөн цахимаар бэлтгэж, түгээхээр шийдвэрлэлээ. Ингээд бидний бэлтгэсэн ээлжит жилийн тайланг хүлээн авч, болгооно уу.

Юуны түрүүнд та бүхэнд 2019 онд болсон гол үйл явдлыг хураангуйлан хүргэхийн зэрэгцээ үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээллийг тайланд дэлгэрэнгүй танилцуулахаар бэлдлээ. Залгуулаад та манай хөрөнгө оруулалттай компаниудын товч тайлантай танилцах боломжтой ба Ард Санхүүгийн Нэгдлийн аудитлагдсан тусдаа болон нэгтгэсэн санхүүгийн тайланг энэ товхимлын төгсгөл хэсгээс уншиж, танилцах боломжтой юм.

Улиран одсон 2019 он бидний хувьд үйл явдлаар арвин байлаа – бид 5.4 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан, бид нээлттэй компани болсон, бид Ард Аппаа нэвтрүүлсэн, бид IPO хийж мөнгө босгосон, бид Монголынхоо анхны блокчэйн дээр суурилсан криптокойныг гаргасан, бид багаа чадварлаг гишүүдээр бэхжүүлсэн, бид хэлсэн бүхнээ давуулан биелүүлсэн гээд тоочиж болно.

Би асуудлыг ач холбогдлынх нь эрэмбээр дэс дараатай толилуулахыг хичээе. Болгоон соёрхоно уу.

2019 онд Ард Санхүүгийн Нэгдэл үйл ажиллагааны хувьд 3.4 тэрбум төгрөг буюу нийт 5.4 тэрбум төгрөгийн дэлгэрэнгүй ашгийг бүртгэж ажиллалаа. Манай тусдаа баланс 78.1 тэрбум төгрөгт хүрсэн бол хөрөнгө оруулалтын маань багц 68.2 тэрбум төгрөг боллоо. Бид өнгөрсөн жил АрдКойныг анхлан гаргасны хувьд хувьцаа эзэмшигчдэдээ ARDX 1 тэрбумыг хувь тэнцүүлсэн урамшуулал болгон олгож байсан бол энэ жил анх удаагаа ногдол ашиг тараах шийдвэрийг гаргаж, 1 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ тараах болсныг дуулгахад таатай байна. Баяр хүргэе, та бүхэндээ – та бидний хамтын итгэл, зүтгэл ийм сайн үр дүн гаргасаар байна!

Өнгөрөгч 8 дугаар сард бидний олон жил төлөвлөж, хийж, ярьж, хүлээж ирсэн ажил хэрэгжсэн билээ – Ард Санхүүгийн Нэгдэл хувьцаат компани Монголын Хөрөнгийн Бирж дээр чөлөөтэй арилжаалагддаг компани болж чадлаа. Бид AARD гэх тикертэй арилжаалагдаж байгаа бөгөөд оны сүүлчээр хамгийн идэвхтэй арилжаалагддаг үнэт цаасны тоонд зүй ёсоор орсон юм.

A black and white portrait of a middle-aged man with short, dark hair, wearing a dark suit, white shirt, and a striped tie. He is sitting on a stool, with his hands clasped in his lap. The background is a plain, light color.

**Хутагт овогтой Чулууны Ганхуяг**  
**Гүйцэтгэх Захирал**

//

Монголчууд дотроо ойлголцож, бие биенээ түшиж ажиллавал илүү хол явж, улс орны хөгжлийг хурдасгаж, олон улсын зах зээл дээр өөрийн өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломжтой гэдэгт итгэдэг.

Ард Кредитын IPO хийгдэж, тус компанийн 25 хувийг бид олон нийтэд амжилттай санал болгон нийт 1,763 хүнээс 5.3 тэрбум төгрөг босгосноор Ард Санхүүгийн Нэгдэлийн үнэлгээ 8.9 тэрбум төгрөгөөр өсч, харин бидний Ард Кредитэд эзлэх хувь 60.88 хувь болж буурсан юм. Ард Кредит 76.3 орчим мянган зээл олгож, 2.2 тэрбум төгрөгийн ашиг үйлдвэрлэлээ. Мөн Япон улсын Крауд Кредит Сантай хамтран ажиллах санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурснаар нийт 5 сая доллартай тэнцэх төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр болсон.

Бид оны эхэнд Хөрөнгө Оруулагч Үндэстэн – 2019 Форумын үеэр Монголын анхны супер аппликэйшн болох Ард Аппыг олон түмэндээ танилцуулж, санал болгосон билээ. Энэ аппликэйшн бүхий л утгаараа супер болж чадсан гэж бид үзэж байгаа: харилцагч ухаалаг гар утсаа ашиглан өөрөө өөрийгөө бүртгүүлэн зээл авах эрх нээгдэж, хадгаламжийн данс нээлгэн, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд хамрагдаж, үнэт цаасны арилжаанд оролцож, цахилгаан, байр, утасныхаа төлбөрийг төлж, хүнсний болон барааны дэлгүүрээр үйлчлүүлээд зогсохгүй хийсэн үйлдэл, гүйлгээ бүртээ АрдКойноор урамшуулал авч, түүнийгээ цуглуулах, арилжаанд оролцох боломжийг нээсэн апп болсон юм. Ард Аппын бүртгэлтэй хэрэглэгчид 260 мянгад хүрч, Ард Койн хэрэглэгчдийн тоо 170 мянгад хүрэв. Харин Ард Кредит Монголбанкнаас цахим мөнгө, төлбөр тооцооны зөвшөөрөл авахаар өргөдлөө өгсөн болно.

Манай ТУЗ-ийн 2019 оны отгон хурлаас Ард Лайфыг дахин хөрөнгөжүүлж, нийт 15 тэрбумын хөрөнгө оруулалтыг хийх зөвшөөрлийг гаргасан билээ. Ингэснээр хувийн тэтгэврийн сангийн тухай хууль гармагц Ард Лайф зах зээл дээр түрүүлж хөдлөх боломжтой болж байна гэж харж байна.

2018 оны сүүлээр бид онлайн худалдааны салбарт Ард Шопыг нэвтрүүлэх шийдвэр гаргасан ба Ард Шоп өнөөдөр худалдан авагч, борлуулагч, хүргэлт гэсэн 3 том бие даасан системийг боловсруулж дуусгаад бүрэн ашиглаж байна. Монгол Улсад анх удаа Монгол Шуудантай системийн холболт хийснээр бүх орон даяар хүргэлттэй онлайн худалдааны платформ болсон бөгөөд эхний ээлжинд БНХАУ-ын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг Монголынхоо хэрэглэгчдэд хамгийн хямд үнээр санал болгож эхэллээ. Дөрөвдүгээр улиралд бид Туркийн шуудангийн олон улсын цахим дэлгүүртэй хамтран ажиллах гэрээ байгуулснаар хамгийн хямд, хамгийн өргөн сонголттой цахим дэлгүүр болох зорилгодоо үндсэндээ хүрч байна. Ард Шоп нь өөрийн тусдаа вэб хуудас ба аппаас гадна Ард Апп дотор байршсан нь манай харилцагчдад шууд худалдан авалт хийх, төлбөр тооцоогоо түргэн гүйцэтгэх, АрдКойноор урамшуулал авах зэрэг олон давуу талууд олгож байна. Мөн төлбөр тооцоондоо Кэнди, Редпойнт, АрдКойн зэрэг хамгийн олон төрлийн урамшууллын онооны системийг ашиглан худалдан авалт хийх боломжуудыг бүрдүүлснээр цахим худалдааны цар хүрээ, хэрэглээг улам нэмэгдүүлж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл 2019 онд санхүүгийн тайлан балансын хувьд бүтцийн асар том өөрчлөлтийг хийв: актив талд стратегийн ач холбогдолтой хөрөнгө оруулалт болон холбогдох этгээдээс авах авлага л үлдлээ. Гуравдагч этгээдэд өгсөн зээл, стратегийн бус хөрөнгө оруулалтуудаас салж, холбогдох компаниуд хоорондын авлага, өглөгийг сайтар цэвэрлэв. Нөгөө талдаа бид бондын санхүүжилтийг эрчимжүүлж, банкны өр зээлээ хаалаа. Үүний үр дүнд санхүүгийн зардлыг бууруулж ажиллаж чадсан юм. Ингэснээр Ард Бит болон Ард Холдингс Интернэйшнл компаниудад AARD-ийн 15 хувийг тус бүр эзэмшүүлэх болов.

Компанийн нийт хөрөнгө 78 тэрбум төгрөгт хүрч, хувьцаа эзэмшигч та бүхний хөрөнгийн үнэ цэнэ 7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 57 тэрбум төгрөгт хүрэв. Монгол Шуудан 1.1 тэрбум, Ард Даатгал 1.7 тэрбум, Ард Кредит 2.2 тэрбум төгрөгийн ашигтай тус бүр ажилласан нь манай багцын өсөлтөнд гол үүргийг гүйцэтгэв.

Монголын Хөрөнгийн Бирж дээрх арилжаанд манай дөрвөн компани зонхилох байр суурьтай болов. Зах зээлийн хөгжил сул байгаа нь бидэнд боломжийг олгож байгаа бөгөөд бид даатгал, тэтгэврийн сангуудаараа зах зээл дээрх гол хөрөнгө оруулагч болж эхэллээ. 2019 оны гүйцэтгэл дээр тулгуурлан манай багцын 4 компани дөрвүүлээ Монголын Хөрөнгийн Биржийн ТОП20 Индекс бичигдэх болсон юм.

Группын хувьд нийт 3.3 тэрбум төгрөгийн өөрийн хувьцааг худалдан авсан бөгөөд оны сүүлчээр

Монгол Шуудангийн 3.6 хувийг нэмж худалдан авах шийдвэрийг гарган 2.2 тэрбум төгрөгийн гэрээг үзэглэв. Ард Шопын гэрээгээр бид 240 сая төгрөгийн төлбөр хийсэн бол 8 тэрбумын үл хөдлөх хөрөнгийн наймааг хийж гүйцэтгэжээ.

Монгол Улсад анхных нь болох блокчэйн дээр суурилсан АрдКойн нь гадаад дотоодын 3 бирж дээр бүртгэгдэн арилжаалагдаж эхэлсэн бөгөөд CoinMarketCap, Blockfolio, LiveCoinWatch зэрэг тэргүүлэх платформууд дээр нэвтэрч чадлаа. АрдКойныг эрхлэн гаргадаг АрдБитыг Сингапурт бүртгүүлэх ажиллагаа явагдсаар байна.

Системийн хувьд бизнесийн хяналтын Табло, бизнесийн үндсэн систем болох Поларисыг группын хэмжээнд нэвтрүүлэв.

Маркетингийн хувьд бид ажлаа идэвхжүүлж, өөрийн гэсэн өнгө төрхийг харуулсан шинэлэг олон ажил хийж гүйцэтгэлээ. Олны дунд Ардыг таниулах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Монгол HD телевизийн өглөөний хөтөлбөрийн мөнгө санхүүгийн буланг ажиллуулж, боловсролын салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор Боловсрол телевизийн Би Багш нэвтрүүлгийг ивээн тэтгэв.

Сошиал медиа сувгаар харилцагч, дэмжигчидтэйгээ өдөр бүр харилцаж, тэдний дунд урамшуулалт уралдаан, тэмцээнүүдийг оны туршид зохион байгуулав. Хэрэглэгчид Ард Апп ашигласны урамшуулалд цуглуулсан АрдКойноороо автомашины азтан шалгаруулах 2 удаагийн

хөтөлбөрт оролцлоо. Өнгөрсөн жил бид нийт 1.5 тэрбум ширхэг АрдКойныг харилцагчдадаа урамшууллаар олгосон байна.

Цахим худалдааны хямдрал, урамшууллын хамгийн том арга хэмжээ болох Цагаан Сугарыг анх удаа зохион байгууллаа.

Харилцагчдад үйлчлэх Дуудлагын төвийг ажиллуулж, харилцагчийн хүссэн мэдээллийг нь түргэн шуурхай хүргэж ажиллав.

Михаил Зелдович, Жеймс Андерсон, Мөнх-Очирын Сэргэлэн нар 4 дүгээр сард болсон хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-д сонгогдсон бол 9 сард Арно Вентура нэмэгдэж орж ирлээ. ТУЗ-ийн Нарийн Бичгийн Даргаар Хангайн Хулан ажиллаж байгаа бол Арьяасүрэнгийн Батболд Байгууллагын Нарийн Бичгийн Даргын албыг давхар хашиж эхлэв.

Ард Санхүүгийн Нэгдлийн Хөрөнгө Оруулалт Эрхэлсэн Захирлаар Энхсайханы Амарбаясгалан, Маркетинг Эрхэлсэн Захирлаар Баяраагийн Ариунаа, Ард Лайфын Гүйцэтгэх Захирлаар Булганы Гантулга ажиллаж эхэллээ. Харин оны дундуур Ард Кредитын Гүйцэтгэх Захирал Чулууны Ганзориг ажлаа өгснөөр шинэ Гүйцэтгэх захирлын эрэл хайгуул хийгдэж, 2020 оны эхнээс Гэрэлтийн Тэлмэн түүнийг орлон ажиллахаар болов. Хууль Эрх Зүйн Нийцлийг хариуцах хүний эрэл амжилттай болж Сүхбаатарын Анар-Эрдэнэ 2020 оны 2 дугаар сараас эхлэн ажиллаж эхэлсэн бол компанийн эрсдэлийн удирдлагыг Баярсайханы Оюутцэцэн хариуцан ажиллахаар болов.

Бид ажилчдын хөрөнгө оруулалтын компани болох EIT-ээр дамжуулан жил бүр нэг сарын цалинтай дүйцэх хэмжээний хувьцаа эзэмших эрхийг нийт ажилтнууддаа эдлүүлсээр 3 жил боллоо. Үүний хажуугаар бид 2 жилийн локаптай Ард Даатгал,

Ард Кредит, Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааг нийт ажилтнууддаа эзэмшүүлсэн бөгөөд 195 саяыг ТУЗ-ийн гишүүдэд, 446 саяыг удирдлагын багт, 117 саяыг ажилтнуудад хуваарилав.

Нийгмийн хариуцлагын хүрээнд 2019 онд Группын хэмжээнд аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 431 сая төгрөгийг, хувь хүний орлогын албан татварт 333 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 930 сая төгрөгийг, бусад татварт 311 сая төгрөгийг буюу нийтдээ 2 тэрбум төгрөгийн татвар, шимтгэлийг улсын төсөвт бүрдүүлсэн байна. Үүнээс гадна 100 гаруй сая төгрөгийг ажилтнуудын хувийн тэтгэврийн сангийн дансанд Ардын компаниудаас байршуулж, ажилтнуудынхаа ирээдүйн санхүүгийн баталгааг бэхжүүлэв.

Сүүлийн 16 жилийн туршид бидний зүгээс уйгагүй зүтгүүлсэн ажил үр дүнгээ өгч, тэтгэврийн шинэчлэл Монгол Улсад хийгдэх хөрс, суурь тавигдлаа. Үүний хажуугаар даатгалын салбарын шинэчлэл, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах нийгэмд чиглэсэн олон төрлийн ажлыг бид хийсээр байна. 2019 онд бид 2 удаа Хөрөнгө Оруулагч Үндэстэн Форумд хийж амжууллаа. Энэхүү арга хэмжээ нь Монголын хөрөнгө оруулалтын хамгийн том арга хэмжээ хэвээр байгаад баяртай байна.

Бид Төв Азид өргөжин тэлэх боломжийг судалж эхлэв. Хөрөнгө оруулалтын судалгаа шалгалтыг Казахстан, Киргизстанд хийв. Манай хөрөнгө оруулалтын сангийн зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрснөөр бид Үндэсний Хувьчлалын Сангийн үйл ажиллагааг 2020 онд эхлүүлэх боломж бүрдлээ.

Бид банканд хөрөнгө оруулалт хийхээр бэлтгэл ажлыг эхлүүллээ. Үүний зэрэгцээ Ард Санхүүгийн Нэгдэл дунд хугацаанд олон улсын бирж дээр

бүртгэлтэй болохоор зэхэж байна. Ард Холдингс Интернэйшнл, Ард Лизинг үйл ажиллагаагаа эхлүүлээд байгаа бол Ард Пропертиз, Ард Рийл Эстэйт компаниудыг улсын бүртгэлд хамрууллаа.

Энэ тайланг бичих үед дэлхий даяанаа дэгдсэн коронавирусын цар тахал нийгэм, эдийн засагт хүчтэй цохилт өгч, бизнесийн үйл ажиллагаанд савалгаа үүсгэх нь тодорхой болсон тул гүйцэтгэх удирдлага компаниудынхаа үйл ажиллагааг тасралтгүй явуулах талын бүхий л арга хэмжээг авч, ажиллагсдынхаа эрүүл мэндэд онцгойлон анхааран ажиллаж байна. ТУЗ-ийн хурлууд ээлжит бусаар хийгдэж, төсөв, төлөвлөгөөнд тодотголуудыг хийж байна. Бид зарим нэгэн ажлаа хойш нь тавьж, тэвчиж болох зардлуудыг танах чиглэлийг Нэгдлийн түвшинд гаргаж, хэрэгжүүлж эхэлсэн болно. Нэг зүйлд харин манай баг итгэлтэй байгаа – бидний хамтдаа бүтээж босгосон нэгдэл компани

энэ хямралыг даван туулахад бэлэн байгаа. Анх төлөвлөхөөсөө авахуулаад, зорин байж босгосон, сэтгэлээ шингээж ажилласан бүхэн өнөөгийнх шиг гүнзгий хямралыг ажралгүй даван туулахад зориулагдсан болно.

Энэ цаг үед хувьцаа эзэмшигч та бүхэн эрүүл мэнд, аюулгүй байдалдаа онцгойлон анхаарахыг дахин сануулахын ялдамд Ардынхаа үйлчилгээг супер Аппаараа авч хэвшихийг хүсье.

Багаа төлөөлөн мэндчилэн ёсолсон,

**Хутагт овогтой Чулууны Ганхуяг**  
**Гүйцэтгэх Захирал**

## **Эрхэм зорилго**

---

Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлооно

## **Алсын хараа**

---

Бүс нутагтаа тэргүүлэгч финтек нэгдэл болох

## Мөрдөх зарчим

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж ажиллана;

Ёс зүйн хэм хэмжээг өндөрт тогтоон дагаж, хууль тогтоомжийг чандлан мөрдөхийн зэрэгцээ хүйсийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллана;

Хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэлийн харьцааг зохистой түвшинд барьж ажиллана;

Сайн засаглал, ил тод байдлыг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлэн ажиллана;

Нээлттэй уян хатан бодлого баримталж, зах зээлийн мэдрэмжтэй, хурдан шуурхай ажиллахыг эрмэлзэнэ;

Шинийг нэвтрүүлж, манлайлах бодлогыг мөрдөж ажиллана;

Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг чандлан мөрдөнө;

Хамгийн авьяаслаг, хүчирхэг, мэргэжлийн, цомхон, үйл хэрэгтээ үнэнч хамт олныг бүрдүүлж ажиллах бөгөөд шинээр ажилд орох босгыг өндөрт тогтоож, ажлын байранд тавигдах шаардлага, хариуцлагыг чанд мөрдөнө;

Нийгмийн хариуцлага өндөртэй, нийгэмд эерэг өөрчлөлтийг түүчээлж ажиллана;

Хууль эрх зүйн болон бизнесийн орчиндоо шаардагдаж буй өөрчлөлтүүдийг бий болгохын төлөө санаачилга гаргаж ажиллана;

Байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах шилдэг стандартыг нэвтрүүлж ажиллана;

Бүтээгдэхүүн үйлчилгээндээ өөрсдийн итгэл үнэмшил, философийг шингээж ажиллана.

## Давуу шинж чанар

Өрсөлдөх чадвар, үр ашиг болон дэвшилтэт технологийг цогцлуулсан түншлэл;

Амжилттай хөрөнгө оруулалтын туршлага, ил тод засаглал;

Шинэ санаа, төслийг хэрэгжүүлэгч олон улсад танигдсан хамт олон;

Хөрөнгө оруулалтын тогтвортой өгөөж;

Зах зээлийн боломжийг хөрөнгийн үнэ цэн болгох туршлага;

Хөрөнгө оруулагч үндэстэн танигдсан брэнд;


Үндэсний хэмжээний цогц дэд бүтэц;

Энтрепренёр соёл.


# 2019 он

## Тоогоор


Нийт үнэлгээ  
(сая төгрөг)




Нийт ашиг  
(сая төгрөг)




Нийт хөрөнгө  
(сая төгрөг)



Эздийн өмч  
(сая төгрөг)



Хөрөнгө оруулалтын багц  
(сая төгрөг)



| Сая төгрөгөөр                      | 2018       | 2019              | Өөрчлөлт |
|------------------------------------|------------|-------------------|----------|
| Зээлийн багц                       | 9,836      | <b>5,312</b>      | -45.99%  |
| Үндсэн хөрөнгө                     | 971        | <b>769</b>        | -20.80%  |
| Стратегийн хөрөнгө оруулалтын багц | 40,331     | <b>67,288</b>     | 79.14%   |
| Тактикийн хөрөнгө оруулалтын багц  | 3,480      | <b>950</b>        | -72.70%  |
| Нийт хөрөнгө                       | 60,467     | <b>78,072</b>     | 29.12%   |
| Богино хугацаат өр төлбөр          | 2,234      | <b>4,873</b>      | 118.13%  |
| Урт хугацаат өр төлбөр             | 7,722      | <b>16,617</b>     | 115.19%  |
| Нийт өр төлбөр                     | 9,956      | <b>21,489</b>     | 115.94%  |
| Эздийн өмч                         | 50,511     | <b>56,582</b>     | 12.02%   |
| Нийт орлого                        | 5,228      | <b>11,721</b>     | 124.19%  |
| Нийт зардал                        | 4,490      | <b>7,292</b>      | 62.41%   |
| Цэвэр ашиг                         | 668        | <b>3,405</b>      | 409.73%  |
| Нийт ашиг                          | 7,398      | <b>5,448</b>      | -26.36%  |
| Эргэлтэнд буй нийт хувьцаа         | 17,194,364 | <b>27,175,629</b> |          |
| Нийт үнэлгээ                       | 52,599     | <b>59,624</b>     | 13.36%   |
| Нэгж хувьцааны өгөөж (төгрөг)      | 430        | <b>200</b>        |          |
| Нэгж хувьцааны үнэлгээ (төгрөг)    | 3,051      | <b>2,195</b>      |          |

## Санхүүгийн харьцаа үзүүлэлт

|                                 | 2018   | 2019           | Өөрчлөлт (хувь) |
|---------------------------------|--------|----------------|-----------------|
| Зээлийн багц/Хөрөнгө            | 16.27% | <b>6.82%</b>   | -9.45%          |
| Хөрөнгө оруулалт/Хөрөнгө        | 72.45% | <b>87.43%</b>  | 14.98%          |
| Өр төлбөр/Хөрөнгө               | 16.47% | <b>27.53%</b>  | 11.06%          |
| Хөрөнгө оруулалт/Өөрийн хөрөнгө | 86.74% | <b>120.63%</b> | 33.89%          |
| Цалингийн зардал/Нийт зардал    | 20.66% | <b>15.78%</b>  | -4.88%          |
| Хүүний зардал/Нийт өр төлбөр    | 8.58%  | <b>6.78%</b>   | -1.80%          |
| Үйл ажиллагааны зардал/Хөрөнгө  | 4.47%  | <b>6.00%</b>   | 1.53%           |
| ROE (өөрийн хөрөнгийн өгөөж)    | 14.65% | <b>9.63%</b>   | -5.02%          |
| ROA (нийт хөрөнгийн өгөөж)      | 12.23% | <b>6.98%</b>   | -5.25%          |

## Нэгтгэсэн үзүүлэлт

|                                 | 2018    | 2019           | Өөрчлөлт (пункт) |
|---------------------------------|---------|----------------|------------------|
| Нийт компанийн тоо              | 15      | <b>19</b>      | 4                |
| Нийт ажилчдын тоо               | 192     | <b>199</b>     | 7                |
| Нийт зээлдэгчдийн тоо           | 1,078   | <b>25,580</b>  | 24,508           |
| Нийт харилцагчдын тоо *         | 149,936 | <b>386,749</b> | 236,813          |
| Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо * | 4,921   | <b>7,183</b>   | 2,262            |
| Нийт хөрөнгө (сая төгрөг)       | 67,312  | <b>76,757</b>  | 9,445            |
| Нийт эздийн өмч (сая төгрөг)    | 31,283  | <b>20,093</b>  | (11,190)         |
| Нийт цэвэр ашиг (сая төгрөг)    | 3,367   | <b>6,631</b>   | 3,264            |
| Үнэ ба дансны үнэ (PB)          | 1.37    | <b>1.51</b>    | 0.14             |
| Үнэ ба ашиг (PE)                | 12.81   | <b>4.58</b>    | (8.23)           |

\* Охин компаниудын давхардсан дүн (Монгол Шуудан ороогүй)  
2019 оны нэгтгэсэн дүн аудитлагдаагүй болно.

# Компанийн тухай

---

**Анх 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон АНУ-ын Мэрси Кор төрийн бус байгууллага ХасБанкны нийт ажиллагсдад зориулан 600 сая төгрөгийг ажиллагсдын хувьцаа эзэмшүүлэх санд хандивлах шийдвэрийг гаргасан юм.**

Улмаар ХасБанкны ажиллагсад тус сангаас олгогдсон хувьцааны үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх зорилгоор өөрийн хувьцаагаа ХасБанкны толгой компани болох ХАС-ГЭ ХХК-ийн хувьцаагаар солих байдлаар хөрөнгө оруулалт хийсэн болно.

ХАС-ГЭ ХХК нь тухайн үеийн удирдлагын шийдвэрийн дагуу ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болж өөрчлөгдсөн бөгөөд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг томоохон компаниудын нэгдэл болж өргөжсөн юм.

Ард Санхүүгийн Нэгдэл нь 2005 оны 9 сард ХасБанкны үүсгэн байгуулагч, одоогийн Гүйцэтгэх Захирал Ч. Ганхуягийн санаачилгаар “Employee Investment Trust” буюу ИАЙТи ХХК нэртэйгээр байгуулагдсан бөгөөд Монголын анхдагч институционал хөрөнгө оруулагчийн үндэс суурь ийнхүү тавигдсан түүхтэй.

ИАЙТи нь 2005 онд үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн дүрмийн сантай, 10 хувьцаа

эзэмшигчтэй байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар 4,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй, 78 орчим тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж өргөжсөн байна.

2013 онд манай гол хувьцаа эзэмшигчид шинэ стратегийн зорилгоо тодорхойлж, Ард Санхүүгийн Нэгдэл гэх нэрэн дор үйл ажиллагаагаа явуулах түүхэн шийдвэрийг гаргасан юм. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд бид Ард Кредит, Ард Даатгал, Ард Секюритиз, Ард Лайф болон Ард Активд тасралтгүй хөрөнгө оруулж эхэлсэн билээ.


2016 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр болсон томоохон хувьчлалд амжилттай оролцож Монгол Шуудан ХК-ийн гол хөрөнгө оруулагч нь болж чадсан юм. 2017 онд манай үндсэн хөрөнгө оруулалтын багцад хөрөнгө оруулалтын сангийн удирдлагыг хэрэгжүүлэх Ард Менежмент, блокчэйн болон криптовалютын чиглэлээр ажиллах Ард Бит компаниуд нэмэгдсэн байна. 2018 оноос ТэнГэр Системс компани өөрийн үйл ажиллагааны чиглэлд шинэчлэл хийж,



блокчэйн технологи руу шилжиж эхлэв. 2019 онд Ард Пропертиз, Ард Рийл Эстейт, Ард Лизинг, Ард Холдингс Интернэйшнл зэрэг компаниуд байгуулагдаж, нэгдлийн бүтцэд багтаж эхлэв. Бид хүн бүр бүтээсэн баялгаасаа хувь хүртэх ёстой, харилцагч иргэн бүр банкныхаа эзэн нь байх ёстой гэсэн итгэл үнэмшилдээ хөтлөгдөн 2015

онд Ард Холдингсыг хаалттай хувьцаат компани болгосон билээ. 2017 оны төгсгөлд Хөрөнгө Оруулагч Үндэстэн Жинст-Увс нээлттэй ХК-тай урвуу хэлбэрээр нэгдэж МХБ дээр арилжаалагдаж эхэлсэн бол 2019 оны 8 сарын 8-нд Ард Санхүүгийн Нэгдэл RTO хийснээр нээлттэй хувьцаат компани болсон юм.

# 2019 оны онцлох үйл явдал



**1 сарын 15**

Ард Бит компанийн зүгээс АрдКойн лоялти оноог блокчэйн дээр тулгуурлан гаргав. ARDX-ийн талаар ardcoin.com болон etherscan.io дээрээс мэдээлэл авч болно.

**1 сарын 19**

Хөрөнгө Оруулагч Үндэстэн Чуулган зохион байгуулагдаж, Ард Аппын Супер Апп хувилбарыг олон нийтэд танилцуулав.

**2 сарын 19**

Ард Даатгал ХК нь 2018 оны цэвэр ашгийн 50 хувийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар хуваарилахаар шийдвэрлэлээ.

**3 сарын 1**

Ард Кредитын (MSE: ADB) IPO амжилттай болж, жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын захиалга 300 хувь давж биеллээ.

**4 сарын 5**

Ард Апп-аар дамжуулан үнэт цаасны дансаа онлайнгаар нээдэг боллоо.

**4 сарын 8**

АрдКойн Монголын цорын ганц криптовалютын арилжааны платформ болох Trade.mn дээр арилжаалагдах боллоо. ARDX/MNT анхны арилжаа явагдлаа.

**4 сарын 27**

Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Даатгал, Ард Кредит, Жинст Увс ХК-иудын хувьцаа эзэмшигч нарын ээлжит хурал Зайсан Хилл Комплекс зохион байгуулагдав. Хурлын үеэр анх удаагаа Ард Санхүүгийн Нэгдэл 1 тэрбум төгрөгтэй тэнцэх хувь тэнцүүлсэн урамшууллыг бүх хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилав.

**5 сарын 8**

Санхүүгийн Зохицуулах Хорооноос Ард Санхүүгийн Нэгдэл болон Жинст Увс ХК-иудыг нэгтгэх зөвшөөрөл олгов.

**6 сарын 21**

Ард Апп хэрэглэгчдийн тоо 200,000, Ард Кредитын харилцагчдын тоо 100,000 хүрлээ.

**7 сарын 8**

Санхүүгийн Зохицуулах Хорооноос Ард Менежмент ҮЦК ХХК-г Үндэсний Хувьчлалын Сан хаалттай хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулах зөвшөөрөл олголоо.

**7 сарын 23**

Харилцагчид Ardshop.mn-ээр дамжуулан гадаад захиалга хийх боломжтой боллоо.



**8 сарын 8**

Ард Санхүүгийн Нэгдэл Жинст-Увстай нэгдсэнээр нээлттэй компани болж, хувьцааны арилжаа нээгдлээ.

**8 сарын 22**

АрдКойн (ARDX) Австралийн BTCEXA олон улсын бирж дээр арилжаалагдахаар боллоо.

**9 сарын 2**

АрдКойн (ARDX) олон улсын КойнМэрит криптовалют мэдээллийн санд бүртгэгдлээ.

**9 сарын 18**

АрдКойн (ARDX) олон улсын КойнГэкко криптовалют мэдээллийн санд бүртгэгдлээ.

АрдКойн (ARDX) олон улсын томоохон криптовалютын бирж болох Стэкс (STEX) дээр арилжаалагдаж эхэллээ.

**11 сарын 29**

Ард Санхүүгийн Нэгдэл Монгол Шуудан ХК-ийн 3.6 хувийг нэмж авлаа.

**12 сарын 1**

Хөрөнгө Оруулагч Үндэстэн - 2020 чуулга уулзалт "Ирээдүйдээ эзэн байя" уриан дор зохион байгуулагдлаа. Ард Аппын шинэ хувилбар танилцуулав.

**12 сарын 2**

Ард Санхүүгийн Нэгдэл Ард Лайф ХХК-ийг дахин хөрөнгөжүүлэх, үйл ажиллагааг нь тэлэх зорилгоор 9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нэмж хийх шийдвэр гарлаа.

**12 сарын 19**

АрдКойн нь олон улсын криптовалютын платформууд болох CoinMarketCap, LiveCoinWatch болон Blockfolio дээр бүртгэгдлээ.

# Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



| #                               | Хувьцаа эзэмшигч         | 2019              | Хувь          |
|---------------------------------|--------------------------|-------------------|---------------|
| 1                               | Ард Бит                  | 4,243,090         | 14.8%         |
| 2                               | Ард Холдингс Интернэйшнл | 2,874,410         | 10.0%         |
| 3                               | Хишигдорж Батхишиг       | 2,657,214         | 9.3%          |
| 4                               | Бруно Рашле              | 2,074,922         | 7.3%          |
| 5                               | Ард Лайф                 | 1,365,018         | 4.8%          |
| 6                               | Галням Уянга             | 1,330,147         | 4.6%          |
| 7                               | Чулуун Ганхуяг           | 1,239,374         | 4.3%          |
| 8                               | Ард Секюритиз            | 1,007,392         | 3.5%          |
| 9                               | Авир Сүхдорж             | 536,417           | 1.9%          |
| 10                              | Ронкок Лимитэд           | 479,111           | 1.7%          |
| 11                              | Сэдбазар Гэрэлтуяа       | 455,717           | 1.6%          |
| 12                              | Ард Даатгал              | 435,362           | 1.5%          |
| 13                              | И Ай Ти                  | 331,253           | 1.2%          |
| 14                              | Лхагвасүрэн Соронзонболд | 315,069           | 1.1%          |
| 15                              | Масик Энтерпрайзэс       | 269,483           | 0.9%          |
| <b>Топ хувьцаа эзэмшигчид</b>   |                          | <b>19,613,979</b> | <b>68.5%</b>  |
| Бусад хувьцаа эзэмшигчид        |                          | 7,561,650         | 26.5%         |
| <b>Эргэлтэнд байгаа хувьцаа</b> |                          | <b>27,175,629</b> | <b>95.0%</b>  |
| Халаасны хувьцаа                |                          | 1,438,634         | 5.0%          |
| <b>Нийт гаргасан хувьцаа</b>    |                          | <b>28,614,263</b> | <b>100.0%</b> |
| Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо   |                          | 4,063             |               |

# Төлөөлөн Удирдах Зөвлөл

| №  | Овог нэр            | AIC    | AARD      | ADB       | MNP    |
|----|---------------------|--------|-----------|-----------|--------|
| 1  | Чулуун Ганхуяг      |        | 1,239,374 | 666,212   | 2,299  |
| 2  | Пүрэвжаргал Батбаяр | 70,586 | 44,001    |           |        |
| 3  | Бруно Рашле         |        | 2,074,922 |           |        |
| 4  | Мөнх-Очир Сэргэлэн  | 17,407 | 19,890    |           |        |
| 5  | Одончимэд Одбаяр    |        |           |           |        |
| 6  | Жеймс Андерсон      |        |           |           |        |
| 7  | Авир Сүхдорж        | 6,892  | 536,417   | 3,571,428 |        |
| 8  | Чулуун Мөнхбат      | 16,342 |           |           |        |
| 9  | Михаил Зелдович     |        |           |           |        |
| 10 | Хишигдорж Батхишиг  | 19,868 | 2,657,214 |           | 28,315 |
| 11 | Арно Вентура        |        |           |           |        |

MSE: 

MSE: 

MSE: 

MSE: 

# Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ГИШҮҮД

---



**ТУЗ-ийн дарга**

## Пүрэвжаргалын Батбаяр

(ТУЗ-ийн дарга, Ард Санхүүгийн Нэгдэл)

2014 оны 1 сараас Ард Санхүүгийн Нэгдлийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр, 2017 оны 8 сараас ТУЗ-ийн даргаар тус тус томилогдсон Батбаяр нь 20 жилийн хугацаанд Лондон болон Улаанбаатар хотод банк, санхүүгийн салбарт ажиллан туршлага хуримтлуулсан нэгэн юм. Батбаяр нь ЕСБХБ-нд 10 орчим жил ажиллахдаа Монгол Улсад уул уурхай, нефтийн хөрөнгө оруулалтын төслүүд хариуцсан төлөөлөгчөөр, мөн Зүүн Европ, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнууд болон Монголыг хамарсан уул уурхай, газрын тосны салбар дахь томоохон хэд хэдэн шинэ төслүүдийг судалж, санхүүжилтийн гэрээ хэлцэл байгуулах, хэрэгжүүлэх ажлыг гардан гүйцэтгэсэн. Түүний урьд нь гүйцэтгэж байсан бусад ажлуудаас дурдвал, Монгол улсын тэргүүлэх арилжааны банкны нэг "Хаан Банк", худалдаа, үйлдвэрлэл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч "Интергрупп ХХК" болон уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг "Олова ХХК"-д тус тус удирдах алба хашиж байсан.

ИБУИНВУ-ын Свонси хотын Уэльсийн их сургуулийг Эдийн засгийн бакалаврын зэрэгтэйгээр, Лондонгийн Бизнесийн Сургуулийг (LBS) мастерын зэрэгтэйгээр (Masters in Finance) тус тус амжилттай дүүргэсэн тэрбээр одоо уул уурхайн зөвлөгөө, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "RMM Pty Ltd" компанийн ТУЗ-ийн гишүүнээр давхар ажиллаж байна. Мөн Батбаяр нь Монголын Рагбигийн Холбооны ТУЗ-ийн гишүүн юм.



### Ердийн гишүүн

## Чулууны Ганхуяг

(Гүйцэтгэх захирал, Ард Санхүүгийн Нэгдэл)

Чулууны Ганхуяг нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд тус компанийн Гүйцэтгэх Захирлаар ажиллаж байна. Монголын Хөрөнгийн Биржээс 1991 онд хөдөлмөрийн гараагаа эхэлсэн тэрбээр 1997 онд Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг дүүргэж, Монголбанканд хянан шалгагчаар оржээ.

1998 онд НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр Санхүүгийн менежерээр шалгаран ажиллаж байгаад 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г байгуулан Гүйцэтгэх захирлаар нь томилогдсон юм. ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсаар 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн ХасБанк байгуулагдсан юм. Ганхуяг нь ХасБанкийг байгуулагдсан цагаас хойш 2009 оныг хүртэл Гүйцэтгэх захирлаар ажилласан бөгөөд 2009-2010 онд ХасБанкны толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх захирлын албан тушаал, 2010-2012 онд Монгол Улсын Сангийн Дэд сайдын албанд томилогдон тус тус ажиллаж байв. Тэрээр Унгар улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын санаачлагч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Монголын Оюутны Холбооны Ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн УЗ-ийн гишүүн, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ерөнхийлөгч гэх мэт албан тушаал хашиж байснаас гадна Монгол Улсад анхлан хадгаламж зээлийн хоршооны хөдөлгөөнийг 1990-ээд оны сүүлээр эхлүүлж, СИДАН ХЗХ-ны Удирдах Зөвлөлийн даргаар ажиллаж байжээ. 2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас түүнийг Дэлхийн Залуу Манлайлагчаар өргөмжилсөн байна. Ганхуяг нь Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгчийн сонгуульт ажлыг давхар хашиж байна.



### Ердийн гишүүн

## Бруно Рашле

(Дэд дарга, Шродер Адвек)

Бруно Рашле 1997 онд Адвек Группыг үүсгэн байгуулж, гүйцэтгэх захирлаар нь ажиллаж байгаад 2017 онд компания Шродер Группд худалдсан байна. Шродер Адвек нь хувийн хөрөнгө оруулалтын менежментийн төрөлжсөн үйлчилгээ үзүүлдэг компани юм. Тус компани нь харилцагч санхүүгийн байгууллагуудаас хуримтлуулсан 10 гаруй тэрбум долларын санг удирдаж, дэлхийн хэмжээнд анхдагч болон хоёрдогч зах зээл дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж байна.

Адвекийг үүсгэн байгуулахаас өмнө Бруно Швейцарийн Мотор-Колумбусын сангийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт ЭмСи Партнерс сангийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байжээ. Ноён Рашле нь 5 тивд байрлах төрөл бүрийн аж үйлдвэрүүдийн төслийг эхлүүлэх, нэмэлт хөрөнгө оруулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх төсөл хөтөлбөрийг удирдаж байсан туршлагатай. Тэрээр Швейцарын Холбооны Технологийн Институтыг барилгын инженерийн чиглэлээр, Стэнфордын их сургуулийн аж үйлдвэрийн инженер мэргэжлээр магистр зэрэгтэй төгссөн бөгөөд 1990 онд Харвардын Их Сургуульд дэвшилтэт менежментийн хөтөлбөрийг дүүргэжээ.



### Ердийн гишүүн

## Авир Сүхдорж

(БСБ Сервис, ГрэйпСити Монгол, МОСТ  
Финтек компаниудын үүсгэн байгуулагч)

ГрэйпСити Монгол ХХК, Мост Финтек ХХК-ийн ТУЗ-ийн дарга А.Сүхдорж нь 1975 оноос Улсын Төлөвлөгөөний комисст ажлын гараагаа эхэлж төд удалгүй Монгол Улсын төв банкны Тооцоолон Бодох төвийн даргаар томилогдон тус газрыг амжилттай удирдаж байжээ. Тэрээр Украин улсын Киев хотын Политехникийн их сургуулийг Компьютерын инженер мэргэжлээр төгссөн.

Социалист тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэний дараахан 1991 онд Монгол улсын анхны мэдээллийн технологийн компани болох БСБ Сервис ХХК (одоо БСБ групп)-ийг үүсгэн байгуулсан байна. БСБ Сервис ХХК-ийн ТУЗ-ийн дарга, ерөнхий захирлаар ажиллаж байх хугацаандаа 2000 онд банк санхүү, төлбөрийн шийдлийн програм хангамжийн компани болох ГрэйпСити Монгол ХХК-ийг үүсгэн байгуулж, 2001 онд сансрын холбооны үйлчилгээ үзүүлэгч Инкомнет ХХК-ийг байгуулсан юм. ГрэйпСити Монгол ХХК нь эдүгээ Монгол улсын банк санхүү, төлбөрийн шийдлийн програм хангамжийн тэргүүлэгч болжээ.

Тэрээр Монголын Мэдээлэл Харилцаа Холбооны хөгжлийн түүчээлэгч бөгөөд банк санхүү, төлбөрийн секторын хөдөлгөгч хүч болсоор ирсэн билээ. Өнгөрсөн 40 жилийн хугацаанд олон тооны амжилттай төслүүд хэрэгжүүлсэн бөгөөд 2008 онд улсын хэмжээний анхны төлбөрийн үйлчилгээний оператор компанийг байгуулж (Мост Финтек ХХК), 2012 онд цахим төлбөр тооцооны МостМони мобайл хэтэвч үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн юм.



### **Ердийн гишүүн**

## **Хишигдоржийн Батхишиг**

**(Гүйцэтгэх захирал, Хишиг Арвин Индустриал)**

Хишигдорж Батхишиг нь 2010-2014 онд БНХАУ-ын Шанхай хотын Тонжи их сургуульд Улс төр судлаач, нийтийн удирдлага мэргэжлээр сурч, 2014-2015 онд Монгол Улсын их сургуулийн Хуулийн сургуульд Олон улсын эрх зүйч мэргэжлээр магистрын зэрэг хамгаалсан юм.

Х.Батхишиг нь 2014-2015 онд Хишиг Арвин Индустриал ХХК-д Бизнес хөгжлийн менежер, 2015 оноос эхлэн гүйцэтгэх захирал мөн 2016 оноос Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-д Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.



**Ердийн гишүүн**

## **Одончимэдийн Одбаяр**

**(Дэд захирал, Эрдэнэс Монгол ХХК)**

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Дэд захирал О.Одбаяр нь 1984 онд Нийслэлийн 13-р дунд сургууль, 1984-1988 онд Зөвлөлт Холбоот Улсын Киев хотын Багшийн Их Сургуульд багш мэргэжлээр, Монгол Улсын магистр зэрэгтэй, АНУ-ийн Флорида мужийн Техникийн Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд олон улсын эдийн засагч мэргэжлээр, 1997-2000 оны хооронд Отгонтэнгэр Их Сургуульд хуульч, эрх зүйч мэргэжлээр, 2017 онд АНУ-ын Бостон хотын Харвардын Их Сургуульд удирдлагын чиглэлээр суралцаж төгссөн.

Тэрбээр Монгол Хятадын хамтарсан Төрийн Өмчит Улсын Үйлдвэрийн Газрын захирлаар, Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Атташе, Гуравдугаар нарийн бичгийн дарга, 2010-2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, “Алтай Холдинг” ХХК-ийн Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байгаад 2016 оноос Төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК-ийн Бизнес хөгжлийн асуудал эрхэлсэн Дэд захирлын албыг хашиж, төрийн өмчит аж ахуйн нэгж, стратегийн ач холбогдол бүхий ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, байгалийн баялгийг олборлох, боловсруулах, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн төслүүдийг удирдан түүний үр өгөөжийг баялгийн сангаар дамжуулан Монгол улсын нийт ард иргэдэд хүртээх ажлыг хийж гүйцэтгэж байна.

“Эрдэнэс Монгол” ХХК нь 13 охин компани, түүний дотор Эрдэнэс Оюу толгой ХХК (34%), Эрдэнэс Таван толгой ХК (100%) зэрэг дэлхийн хэмжээний зэс-алт, коксжих нүүрсний уурхай, Багануур ХК (75%), Шивээ-Овоо ХК (90%) зэрэг компаниудыг эзэмшиж, удирдан чиглүүлж ажилладаг.



### **Хараат бус гишүүн**

## **Чулууны Мөнхбат**

**(Ерөнхийлөгч, Саусгоби сэндс)**

Ч. Мөнхбат Саусгоби сэндс ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирлаар 2015 оны 9 сарын 7-ны өдрөөс томилогдон ажиллаж байна. Ч. Мөнхбат Саусгоби Ресурс компанид Зөвлөхөөр ажиллаж эхэлсэн бөгөөд улмаар Саусгоби сэндс ХХК-ийн Засгийн газрын харилцаа, Бодлогын хэрэгжилт хариуцсан захирлаар ажиллаж байв. Үүний өмнө Ч. Мөнхбат Азийн хөгжлийн банканд Төслийн захирлаар, Дэлхийн банканд Зохицуулагчаар тус тус ажиллаж байв.

Ч. Мөнхбат ОХУ-ын Ленинград хотын дээд сургуулийг хуульч мэргэжлээр төгссөн ба Монгол Улсын Удирдлагын академийн Төрийн удирдлагын магистр зэрэгтэй юм. Мөн тэрээр 1998 онд Шинэ Зеланд Улсын Вайкато их сургуульд Төрийн бодлого, удирдлагын чиглэлээр дахин магистрын зэрэг хамгаалсан юм. Түүнчлэн Ч. Мөнхбат нь Шинэ Зеланд Улсаас Монгол Улс дахь Өргөмжит консулаар ажиллаж байна.



## Мөнх-Очирын Сэргэлэн

(Ерөнхийлөгч, Техник Технологийн ДС)

М. Сэргэлэн нь Техник Технологийн Дээд сургуулийн Ерөнхийлөгч, Монгол Коосэн Коллежийн захирлаар тус тус ажиллаж байна. Өмнө нь тэрээр TCI компанийн захирал, MAC компанийн захирлаар тус тус ажиллаж байв. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр 2018 оны 5 сараас ажиллаж эхлэв.

**Хараат бус гишүүн**

М. Сэргэлэн Бизнес олон улсын дээд сургуулийг нягтлан бодогч, Япон улсын Исити коллежийг менежментийн чиглэлээр тус тус төгссөн.



## Михаил Зелдович

(Хяналтын зөвлөлийн дарга, Кокуун капитал)

Михаил Зелдович хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулалт хийх, худалдааны хэлэлцээр хийх, зөвлөгөө өгөх, ТУЗ-ийг удирдсан хорь гаруй жилийн туршлагатай мэргэшсэн хөрөнгө оруулагч бөгөөд түүхий эдийн арилжаа эрхлэгч юм. Тэрээр 2.2 тэрбум долларын хөрөнгө оруулалтын сангийн менежерээр ажиллаж байсан ба Бостон Консалтинг Группын зөвлөх, АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын худалдааны хэлэлцэгчээр тус тус ажиллаж байсан. Ноён Зелдович Харвардын Хуулийн сургууль болон Флетчерийн Хууль, Дипломатын сургууль төгссөн. Одоогоор Зелдович Зүүн Өмнөд Азийн үр тарианы хөрөнгө оруулалтын сан Кокуун Капиталын ТУЗ-ийн даргаар ажиллаж байгаа ба ногоон технологи, хөдөө аж ахуйн технологи, цахим аюулгүй байдал, байгалийн баялгийн салбарт бие даан хөрөнгө оруулдаг.

**Хараат бус гишүүн**

Михаил дэлхийн зах зээл дээр түүхий эд арилжаалагч компанийн бүс нутгийн тэргүүнээр 10 гаруй жил ажиллаж байна. Монгол улсын эрчим хүчний хараат бус байдалд үзүүлсэн хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, түүнийг Алтан гадас одонгоор шагнажээ.



### **Хараат бус гишүүн**

## **Жеймс Андерсон**

**(ТУЗ-ийн дарга, Азийн Кредит Сан)**

Жеймс Андерсон нь банк, бичил санхүүгийн чиглэлээр мэргэшсэн бөгөөд Төв Ази болон Монголын банкны салбарт бичил санхүүгийн байгууллага, банк бус санхүүгийн байгууллагуудад ажиллаж байсан туршлагатай нэгэн.

Тэрээр ХасБанкны ахлах зөвлөхийн албан тушаалд ажиллаж байсан ба ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байсан. Ноён Андерсон одоогоор Киргизийн Азийн Кредит Сан байгууллагын ТУЗ-ийн даргаар ажиллаж байгаа бөгөөд Брюссель хотод байрладаг бичил санхүүгийн байгууллага болох Алтерфин гэх хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт хийдэг нийгмийн хөрөнгө оруулагч байгууллагын хөрөнгө оруулалтын хорооны гишүүнээр ажиллаж байна. Тэрээр арилжааны банкны суурь мэдлэгтэй бөгөөд Нью-Йорк, Токио зэрэг хотуудад удирдах албан тушаал хашиж байсан.



### Хараат бус гишүүн

## Арно Вентура

(Үүсгэн байгуулагч, Баобаб Групп)

Арно Вентура нь бичил болон жижиг бизнесүүд рүү чиглэсэн, Африк тив болон Хятад улсад тэргүүлэгч дижитал бичил санхүүгийн групп болох Баобаб Группын үүсгэн байгуулагч билээ.

Баобаб-ын эрхэм зорилго нь үйлчлүүлэгчдэдээ энгийн, амар хялбар санхүүгийн үйлчилгээ үзүүлэх замаар тэдний боломж бололцоог нээхэд туслах явдал юм. 2005 онд МикроКред нэртэйгээр үүсгэн байгуулагдсан тус компани нь 2018 онд 1 тэрбум евротой тэнцэх санхүүжилтийг цахимаар болон мянга гаруй салбар, үйлчилгээний цэгүүдээрээ дамжуулан олгосон.

Баобаб нь Африкт болон Хятадад үйл ажиллагаагаа явуулдаг 4,000 гаруй ажилтантай бөгөөд нэг сая орчим харилцагчидтай. Баобаб-ыг үүсгэн байгуулахаас өмнө Арно Вентура нь Планет Финанс гэх олон улсын хөгжлийн болон бичил санхүүгийн салбарт тэргүүлэх олон улсын байгууллагыг үүсгэн байгуулахын сацуу Позитив Экономик Форум хэмээх нийгэмд чиглэсэн Европын томоохон чуулга уулзалтыг санаачлан, хамтран зохион байгуулж байсан.

Арно 2005 онд Францын Залуу удирдагчаар, 2013 онд Дэлхийн эдийн засгийн форумас Дэлхийн залуу удирдагчаар тус тус нэрлэгдсэн байна.

Планет Финансыг үүсгэн байгуулахаасаа өмнө тэрээр Франц, Аргентинд БНП Парибас банканд ажиллаж байсан бөгөөд Франц, Тайландад тэргүүлэх интернетийн үйлчилгээг ханган нийлүүлэгч компанийг үүсгэн байгуулах ажилд гар бие оролцсон байна.

## Гүйцэтгэх удирдлагын баг

---



**Чулуун ГАНХУЯГ**

Гүйцэтгэх захирал



**Батбилэг ЗОЛБОО**

Санхүү эрхэлсэн захирал



**Жаргалан АЛТАНГҮНИЙ**

Үйл ажиллагаа хариуцсан захирал



**Баяраа АРИУНАА**

Маркетинг хариуцсан захирал



**Гарьд ТЭНҮҮН**

Дижитал технологийн захирал



**Энхсайхан АМАРБАЯСГАЛАН**

Хөрөнгө оруулалт хариуцсан захирал



**Мөнхбат МӨНХ-ЭРДЭНЭ**

Дотоод аудитор



**Аръясүрэн БАТБОЛД**

Байгууллагын нарийн бичгийн дарга



**Сүхбаатар АНАР-ЭРДЭНЭ**

Хууль эрх зүй, хянан нийцүүлэлт эрхэлсэн захирал



**Хангай ХУЛАН**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



**Баярсайхан ОЮУТЦЭЦЭН**

Эрсдэлийн менежер

## Охин компаниудын удирдлага

---



**Галбадрах ЦОГБАДРАХ**

Гүйцэтгэх захирал

Ард Даатгал

---



**Гэрэлт ТЭЛМЭН**

Гүйцэтгэх захирал

Ард Кредит

---



**Жаргалсайхан ЗОЛЗАЯА**

Гүйцэтгэх захирал

Ард Секюритиз

---



**Булган ГАНТУЛГА**

Гүйцэтгэх захирал

Ард Лайф

---



**Ганхуяг БИЛГҮҮН**

Гүйцэтгэх захирал

Ард Актив

---



**Гүррагчаа СҮХБААТАР**

Гүйцэтгэх захирал

Ард Лизинг

---



**Энхболд ЗОЛЗАЯА**

Гүйцэтгэх захирал

АрдШоп

---



**Чулуунбаатар ХАНДАА**

Гүйцэтгэх захирал

Ард Менежмент

---



**Гарьд ТЭНҮҮН**

Гүйцэтгэх захирал

ТэнГэр Системс

---



**Бадамрай АНХБААТАР**

Гүйцэтгэх захирал

Монгол Шуудан

---

# Эдийн засгийн орчин

---

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн хэмжээ 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 11.9 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 10.8 их наяд төгрөг болж, нийт орлогын 90.5 хувийг эзэлж байна. Харин нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 11.4 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 627.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.7 хувийг татварын орлого, 8.8 хувийг татварын бус орлого, 8.7 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.8 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна. Татварын нийт орлого 2019 онд 9.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 18.8 хувиар буюу 1.5 их наяд төгрөгөөр өсөв.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 11.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 23.9 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өссөн байна.

Монгол Улс 2019 онд нийт 152 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.7 тэрбум америк доллар, үүнээс экспорт 7.6 тэрбум америк доллар, импорт 6.1 тэрбум америк долларт хүрлээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар буюу 860.6 сая америк доллар, үүнээс экспорт 8.7 хувиар буюу 608.0 сая америк доллароор, импорт 8.0 хувиар буюу 252.6 сая америк доллароор тус тус өсжээ.

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2014 оноос эхлэн ашигтай гарч эхэлсэн бөгөөд 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр ашгийн хэмжээ 1.5 тэрбум долларт хүрч өмнөх оноос 31.3 хувиар буюу 355.4 сая доллароор өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 12 сард улсын хэмжээнд өмнөх оны эцсээс 5.2 хувиар өссөн байна. Инфляцын түвшин 2016 оны 12 сард 1.3 хувь, 2017 оны 12 сард 6.4 хувь, 2018 оны 12 сард 8.1 хувь гарч байсан бол 2019 оны 12 сард 5.2 хувь болж өмнөх оноос 2.9 пунктээр буурсан байна. Инфляцын жилийн дундаж түвшин 2018 онд 6.8 хувь байсан бол 2019 онд 7.3 хувьд хүрлээ.



## Мөнгө, санхүү

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 12 сарын эцэст 20.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар буюу 1.3 их наяд төгрөгөөр өсөхөд төгрөгийн хадгаламж 923.0 тэрбум төгрөгөөр, валютын хадгаламж 464.2 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Мөн гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны эцэст 897.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар буюу 71.2 тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэхүү бууралтад төгрөгийн харилцах 59.0 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 56.0 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Төгрөгийн хадгаламж 2019 оны 12 сарын эцэст 11.1 их наяд төгрөг болж, өмнөх оны эцсээс 9.1 хувиар буюу 923.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Төгрөгийн хадгаламжийн 84.7 хувь буюу 9.4 их наяд төгрөг нь иргэдийн хадгаламж, 15.3 хувь буюу 1.7 их наяд төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж байна. Харин валютын хадгаламж 3.5 их наяд төгрөг болж, өмнөх оны эцсээс 15.4 хувиар буюу 464.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 12 сарын эцэст 18.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар буюу 870.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 52.1 хувь буюу 9.4 их наяд төгрөг нь иргэдийн, 47.9 хувь буюу 8.7 их наяд төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллагынх байна.

2019 оны 12 сарын эцэст хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 15.4 их наяд төгрөг болж, өмнөх оны эцсээс 5.9 хувиар буюу 854.6 тэрбум төгрөгөөр өсжээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 85.4 хувийг эзэлж, өмнөх оны эцсээс 0.7 пунктээр өссөн байна.

Мөн хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 824.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны эцсээс 2.9 хувиар буюу 24.8 тэрбум төгрөгөөр буурснаар нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.6 хувийг эзэлж, өмнөх оны эцсээс 0.3 пунктээр буурсан байна. Харин банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 1.8 их наяд төгрөг болж, өмнөх оны эцсээс 2.3 хувиар буюу 40.6 тэрбум төгрөгөөр өссөнөөр нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.1 хувийг эзэлж, өмнөх оны эцсээс 0.3 пунктээр буурсан байна.



## Хөрөнгийн зах зээл

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжигдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 2.7 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.27 хувиар буюу 182.3 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй гарчээ. Мөн хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компанийн нийлбэр үнэлгээ нь нийт зах зээлийн үнэлгээний 90.8 хувийг эзэлж байгаа бөгөөд Ард Санхүүгийн Нэгдэл, Ард Даатгал, Ард Кредит, Монгол Шуудан энэхүү жагсаалтанд багтаж байна.

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 21,888.16 нэгж, доод үзүүлэлт 17,922.82 нэгж, дундаж үзүүлэлт 19,978.13 нэгж байна. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,844.90 нэгжээр буюу 8.59 хувиар буурч, 19,621.86 нэгж болсон байна.

2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийт 251 удаагийн арилжаагаар 132 компанийн 450.3 сая ширхэг хувьцааг 133.5 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 97.4 мянган ширхэг үнэт цаасыг 9.7 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 143.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 93.3 хувийг хувьцааны арилжааны гүйлгээний дүн, 6.7 хувийг ЗГҮЦ-ны арилжааны гүйлгээний дүн тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд нийт 251 удаагийн арилжаагаар 132 компанийн 450.3 сая ширхэг хувьцааг 133.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан.

Хувьцааны арилжааны 41.87 хувь буюу 55.9 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, 31.8 хувь буюу 42.4 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 3.5 хувь буюу 4.6 тэрбум төгрөгийг тендер арилжаа, 22.8 хувь буюу 30.5 тэрбум төгрөгийг энгийн арилжаа тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 570.5 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж, 1.8 сая ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

**Сүүлийн 5 жилд арилжаалагдсан үнэт цаас (тэрбум төгрөгөөр):**

| Үнэт цаас             | 2015  | 2016  | 2017  | 2018  | 2019  |
|-----------------------|-------|-------|-------|-------|-------|
| <b>Хувьцаа</b>        | 30.5  | 49    | 76.4  | 210   | 133.5 |
| <b>ЗГҮЦ</b>           | 515.5 | 299.6 | 772.5 | 33.5  | 9.7   |
| <b>Компанийн бонд</b> | 0.5   | 0     | 10.2  | 0.6   | 0     |
| <b>Нийт</b>           | 546.5 | 348.6 | 859.1 | 244.1 | 143.2 |

**Валютын зах зээл**

Монголбанкнаас зарласан төгрөгийн доллартай харьцах сарын дундаж ханш 2019 оны 12 сард 2,727.34 төгрөг болж, өмнөх оны эцсээс 3.4 хувиар хувиар суларсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 12 сард 388.75 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар суларсан байна.

Төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2019 оны 12 сард 43.38 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар суларсан байна.

| Үзүүлэлт               | 2016.12  | 2017.12  | 2018.12  | 2019.12  |
|------------------------|----------|----------|----------|----------|
| <b>Америк доллар</b>   | 2,482.57 | 2,433.49 | 2,637.35 | 2,727.34 |
| <b>Жилийн өөрчлөлт</b> | 24.40%   | -2.00%   | 8.40%    | 3.40%    |
| <b>Евро</b>            | 2,619.89 | 2,879.43 | 3,002.43 | 3,030.51 |
| <b>Жилийн өөрчлөлт</b> | 20.60%   | 9.90%    | 4.30%    | 0.90%    |
| <b>Юань</b>            | 358.73   | 369      | 383.03   | 388.75   |
| <b>Жилийн өөрчлөлт</b> | 16.00%   | 2.90%    | 3.80%    | 1.50%    |
| <b>Рубль</b>           | 40       | 41.52    | 39.15    | 43.38    |
| <b>Жилийн өөрчлөлт</b> | 40.00%   | 3.80%    | -5.70%   | 10.80%   |

# Гүйцэтгэлийн тайлан

## Үйл ажиллагааны гүйцэтгэл

2019 оны эхээр бид хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд нээлттэй зохион байгуулдаг Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2019 чуулганаа зохион байгууллаа. Чуулганы үеэр Ард аппыг олон түмэндээ танилцуулж, ухаалаг утсаараа бүхий л үйлчилгээг авах боломжийг харилцагчдадаа нээж өглөө. Гар утсаараа үнэт цаасны данс нээлгэх, онлайн дэлгүүрээс худалдан авалт хийх, даатгалын үйлчилгээ авах, зээлийн хүсэлт илгээгээд шууд зээл авах гэх мэт манай компанийн бүхий л үйлчилгээ багтсанаас гадна цахилгаан, байр, утасны төлбөр төлөх, киноны билет захиалах, фэйсбүүк мессенжер ашиглан бусад руу шимтгэлгүй мөнгө шилжүүлэх гэх мэт олон функцтэй аппаа нэвтрүүлснээ зарлалаа.

2019 онд амжуулсан хамгийн том ажил бол Ард Санхүүгийн Нэгдэл нээлттэй компани болж, Монголын Хөрөнгийн Бирж дээр гарсан үйл явдал байлаа. Мөн Ард Кредит IPO хийж, Ард Бит өөрсдийн анхны блокчэйн дээр суурилсан криптокойныг гаргаж, Ард Санхүүгийн Нэгдэл нь хувьцаа эзэмшигчдэдээ анх удаагаа ногдол ашиг тараах шийдвэрийг гаргаж 1 тэрбум төгрөгтэй тэнцэх Ардкойныг хувьцаа эзэмшигчдэдээ тараалаа. Ард Санхүүгийн Нэгдлийн хамаарал бүхий 4 компани маань Монголын Хөрөнгийн Бирж дээр гарсан цагаасаа эрэлттэй хувьцааны тоонд

багтаж 2019 оны гүйцэтгэл дээр тулгуурлан бүгд ТОП20 Индекс багтсан байна.

2019 оны дундуур Ард койн Монголын цорын ганц криптовалютын арилжааны платформ болох Trade.mn дээр арилжаалагддаг болж, төгрөг, доллар, биткойноор худалдан авах, худалдах боломжийг бүрдүүлэв. Мөн CoinMarketCap, Blockfolio, LiveCoin-Watch зэрэг гадаадын нэр хүндтэй мэдээллийн платформууд дээр бүртгэгдэн арилжаалагдаж эхэллээ. АрдКойныг эрхлэн гаргадаг Ард Битыг бид Сингапурт бүртгүүлэх ажиллагаа явагдсаар байна. 2019 онд Ард Даатгал компанийн маань түүхэн 25 жилийн ойн баяр боллоо. Тэртээ 25 жилийн өмнө өрхөө татаж байсан анхны хувийн даатгалын компани өдгөө Монгол орны аймаг бүрт өөрийн салбартай, даатгалын салбартаа нэр хүндтэй компани болсныг дуулгахад таатай байна.

Оны дундуур Санхүүгийн Зохицуулах Хорооноос Ард Менежмент ҮЦК ХХК-д Үндэсний Хувьчлалын Сан хаалттай хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулах зөвшөөрөл олголоо. Сангийн үйл ажиллагааг 2020 онд эхлүүлэхээр бид ханцуй шамлан ажиллаж байна.

Бид нийгмийн амьдралын идэвхтэй оролцогчийн хувьд хувийн хэвшил, бизнесийн нийтлэг эрх ашгийг





хамгаалах зорилготой CEO Club, Улаанбаатар хотын худалдааны танхим, МҮЦАЭХ-ны УЗ-ийн гишүүнээр ажиллаж ирсэн. Мөн МҮХАҮТ, АмЧам, ВСМ, Еврочамбер гэх мэт байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй байр сууринаас оролцож, хувийн хэвшлийн дуу хоолой болсоор ирлээ. Оны төгсгөлд бид 2020 оныг угтаж Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2020 ээлжит чуулганаа Корпорэйт Конвеншн Сэнтрт “Ирээдүйдээ эзэн байя!” уриан дор зохион байгууллаа. Энэхүү чуулганы гол ач холбогдол бол сүүлийн 16 жилийн туршид бидний зүгээс уйгагүй зүтгүүлсэн ажил биеллээ олж, тэтгэврийн шинэчлэл Монгол Улсад хийгдэх хөрс, суурь тавигдсан явдал байлаа.

Үүний хажуугаар даатгалын салбарын шинэчлэл, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах олон ажлыг бид хийсээр байна.

2019 оны төгсгөлд Ард Санхүүгийн Нэгдлийн ТУЗ-ийн зүгээс Ард Лайф ХХК-ийг дахин хөрөнгөжүүлж, нийт 15 тэрбумын хөрөнгө оруулалтыг хийх шийдвэрийг гаргасан билээ. Улмаар хувийн тэтгэврийн сангийн тухай хууль гармагц Ард Лайф зах зээл дээрх хамгийн том тоглогч байж, анхдагчийн давуу эрхүүдийг эдлэх боломж бүрдэнэ.

## Маркетинг

2019 он нь Ард Санхүүгийн Нэгдлийн маркетингийн хувьд олон чухал үйл явдал өрнөсөн жил байлаа. Ард Апп 2 удаа шинэ хувилбараа олон нийтэд танилцуулж, Хөрөнгө Оруулагч Үндэстэн Форум 2 удаа зохион байгуулагдаж, Монголын анхны блокчэйн дээр суурилсан харилцагчийн урамшууллын оноо болох АрдКойныг зах зээлд нэвтрүүлж, RTO болон IPO хийсэн зэрэг томоохон ололт амжилтуудтай зэрэгцэн брэнд таниулах, хэрэглэгчдийг татах, идэвхжүүлэх, зорилтот хэрэглэгчдэд мэдлэг мэдээллийг түгээх зорилготой олон сувагт маркетингийн кампанит ажлуудыг уламжлалт болон дижитал сувгаар өрнүүлэв. Сайн засаглалтай, нээлттэй компанийн хувьд ил тод байдлыг эрхэмлэж, бүхий л үйл ажиллагаагаа тайлагнан хууль эрх зүйн нийцлийг хангахын хажуугаар нийгэм эдийн засгийн орчиндоо эерэг өөрчлөлтийг манлайлан ажиллав. Бид компанийн зүгээс гаргаж буй шийдвэр, байгууллагын дотоод соёл, гарч буй бизнесийн үр дүн, явуулж буй үйл ажиллагаагаа бүхий л сошиал медиа суваг болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж ирэв. 2019 оны эцэст 420 мянган хэрэглэгч Ард Аппыг татаж, 1.5 тэрбум АрдКойн хэрэглэгчдийн гарт очсон үзүүлэлттэй байв.

Мөн 12 сард болсон Хөрөнгө Оруулагч Үндэстэн Форум, түүгээр онцолсон тэтгэврийн тогтолцооны

шинэчлэл сэдэв олон нийтийн анхаарлыг татаж, нийгэмд уг шинэчлэлийг хийх хүлээлт бий болсныг харууллаа.

Бид маркетингийн бүхий л сувгийг үр дүнтэй ашиглахыг зорьж ирсэн ба тэдгээрийн дундаас сошиал медиа суваг нь бидний хувьд хамгийн чухал, үр дүнтэй суваг юм. Сошиал медиа болон бусад төрлийн дижитал сувгийг идэвхтэй ашиглах нь санхүүгийн бүх үйлчилгээг цахимаар хүргэх бидний зорилготой нийцэхээс гадна хэрэглэгч, үйлчлүүлэгчдээ угтаж үйлчлэх, шууд харилцах өргөн боломжийг нээж байна. 2019 онд Ардын влог, Facebook Live зэрэг сошиал медиад зориулсан сонирхолтой контентыг амжилттай гаргаж, олон зуун мянган хэрэглэгчдэд хүргэлээ. Цаашид дижитал сувгийн маркетингийн үйл ажиллагааг улам нарийн мэргэжлийн, ахисан түвшний хэрэгсэл, нөөц, судалгааг ашиглаж явуулах болно.

2019 онд хамгийн амжилттай явагдсан маркетингийн кампанит ажлын нэг бол автомашины азтантай АрдКойны урамшуулалт хөтөлбөр байв. Автомашины азтан шалгаруулах 2 удаагийн хөтөлбөрт хэрэглэгчид Ард Апп татаж бүртгүүлсэн, түүнийг ашигласны урамшуулалд цуглуулсан АрдКойноороо оролцлоо. Кампанит ажил Ард Аппын хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх, АрдКойныг

зах зээлд нэвтрүүлэх, АрдШоп руу хэрэглэгчийн урсгал татах зорилгодоо амжилттай хүрсэн гэж бид харж байна. Автомашины хоёр дахь ялагч тодрох үед хэрэглэгчид нийт 43 сая АрдКойноор урамшуулалт хөтөлбөрт оролцсон байв. Гурав дахь удаагийн хөтөлбөр орон сууцны болзолтойгоор зарлагдав.

Бид харилцагчид, дэмжигчид, дагагчдаа идэвхжүүлэх бэлэгтэй уралдаан, тэмцээнүүдийг мөн тогтмол явуулж ирлээ. Trade.mn дээр АрдКойны арилжааг идэвхтэй явуулсан, Ард Апп руу АрдКойноо шилжүүлсэн харилцагчдаа ARDX Alpha тэмцээнээр шалгаруулж урамшууллаа. Манай бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд таниулах шилдэг шинэ санаа боловсруулсан залуусыг Project Alpha тэмцээнээр шалгаруулж урамшуулав. Манай компани, бидний үйл ажиллагааны талаарх сонирхолтой баримтуудыг хамгийн сайн мэддэг Instagram хэрэглэгчдийг Ard Quiz уралдаанаар шалгарууллаа. Эдгээр болон бусад урамшуулалт уралдаан, хөтөлбөрүүдийг жилийн туршид зохион байгуулав.

Түүнчлэн өргөн олны дунд брэндээ таниулах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор телевизтэй хамтарсан 2 томоохон төсөл хэрэгжүүлэв. Монгол HD телевизтэй хамтран тус телевизийн Өнөө Өглөө хөтөлбөрийн мөнгө санхүү буланг долоо хоног тутам хөтлөн явуулж, 2019 онд нийт 33 дугаар гаргав. 2020 оны 1 дүгээр улиралд үргэлжлэх энэ хөтөлбөрөөр Ард Секюритиз компанийн Гүйцэтгэх захирал Ж. Золзаяа телевиз үзэгчдэд санхүүгийн зах зээл, хувийн санхүүгийн менежментийн талаар мэдлэг олгохоос гадна Ардын талаарх мэдээ мэдээллийг тогтмол хүргэж ажиллалаа. Мөн Боловсрол Телевизээс зохион байгуулсан дунд сургуулийн багш нарын дундаас шилдэг багшийг шалгаруулах Би Багш уралдаант реалити шоу нэвтрүүлгийг ивээн тэтгэж, Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийг дэмжих нь Ард Санхүүгийн Нэгдлийн хувьд үнэт зүйл мөн болохыг батлан харуулав.

## Хүний нөөц

Ард Холдингс үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн хүний нөөцийн хувьд цомхон, ажиллагсад нь хамгийн боломжит байдлаар давхар үүрэг гүйцэтгэж ирсэн түүхтэй.

2019 оны хувьд Холдингсын хэмжээнд 8 үндсэн ажилтантай ажилласан бөгөөд туслах бүхий л ажлыг гуравдагч компанид гэрээгээр гүйцэтгүүлсэн болно. Санхүү эрхэлсэн захирал, Дотоод аудитор, Үйл ажиллагаа хариуцсан захирал, Маркетингийн захирал нэгдлийн хэмжээнд ажиллаж, Байгууллагын нарийн бичгийн даргын үүргийг Ард Даатгалын Үйл ажиллагаа эрхэлсэн захирал Аръяасүрэнгийн Батболд хавсран охин компаниудын ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарыг чиглүүлэх, хянах, ажлын уялдааг хангаж ажиллав. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүрэгт ажилд Хангайн Хулан 2019 оны дундаас эхлэн ажиллалаа. Хууль эрх зүйн нийцэл хариуцсан захирал Соронзонболдын Халиунаа 2019 оны 6 сараас эхлэн өөрийн хүсэлтээр ажлаа өгч, 2020 оны эхнээс Сүхбаатарын Анар-Эрдэнийг ажилд авав. С.Анар-Эрдэнэ нь БНХАУ-ын Бээжингийн Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн, эдүгээ Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд магистр хамгаалахаар суралцаж байна. Дэнтонс хуулийн фирмийн Бээжин дэх төв оффис, АНУ-ын Шерман Стерлинг хуулийн

фирмийн Бээжин дэх салбар, Улсын Дээд Шүүхийн судалгааны төв, Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцэд тус тус дадлагажин ажиллаж байсан. Дэнтонс хуулийн фирмийн Монгол дахь салбарт хуульчаар ажиллаж байх хугацаандаа хөрөнгө оруулалт, уул уурхай, концесс, компанийн эрх зүйн чиглэлээр мэргэшсэн.

Компани томрохын хэрээр бид тодорхой албан тушаалыг бий болгон үүрэг функцыг тодорхойлон, охин компаниуд дээр давхардал үүсгэлгүй ажиллахыг зорьж ирсэн юм. Оны сүүлээр маркетингийн захирал Цэнд-Аюушийн Должин маань гадагшаа сургуульд явахаар болж Баяраагийн Ариунаа түүний ажлыг залгамжлан авав. Ариунаа нь маркетинг, гүйцэтгэх удирдлагын түвшинд 10 гаруй жил ажилласан туршлагатай ба түүний удирдаж зах зээлд нэвтрүүлсэн төслүүдэд Блю Скай цогцолбор, АНУ-д үйл ажиллагаа явуулдаг Этүгэн Кашемир онлайн брэнд зэрэг багтдаг. Тэрээр Болгар дахь Америкийн их сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэйгээр, АНУ-ын Лос Анжелес дахь Калифорнийн Их Сургуулийн Андерсон Менежментийн сургуулийг бизнесийн удирдлагын мастер зэрэгтэйгээр тус тус төгссөн ба дижитал маркетинг чиглэлээр мэргэшсэн.

Бид 2020 оноос шинээр Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирлын албан тушаалыг бий болгож Энхсайханы Амарбаясгаланг томиллоо. Тэрбээр байгууллагын санхүүгийн удирдлага, хөрөнгө оруулалтын чиглэлээр 20 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд Голомт Капитал, Ньюком Групп, ЭмАйСиСи компаниудад Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн захирлын албан тушаал хашиж байсан юм. Амарбаясгалан нь АНУ-ын Жоржиа их сургуульд Санхүүгийн чиглэлээр Бизнесийн Удирдлагын бакалаврын зэрэг, Индианагийн их сургуульд Санхүү болон Шийдвэрийн Шинжлэх Ухаан чиглэлээр мастер цол хамгаалсан.

Хүний нөөцийн үйл ажиллагааг группын хэмжээнд Үйл ажиллагаа хариуцсан захирал Жаргалангийн Алтангүний хариуцаж ирсэн ч хүний нөөцийн удирдлагыг мэргэшүүлэх, үйл ажиллагааг нь өргөжүүлэх шаардлага гарсан тул Энхбаатарын Уранчимэгийг хүний нөөцийн менежер албан тушаалд томилж, Алтангүний захирлын удирдлага дор өдөр тутмын үйл ажиллагааг явуулж байна.

Уранчимэг нь Бригхам Янг их сургуулийн Хавай дахь салбарыг төгссөн, Скай трейдинг болон Хавайн хамгийн их жуулчдын зорин очдог Полинезийн соёлын төвд хүний нөөцийн менежерээр ажиллаж байсан туршлагатай нэгэн билээ.

Охин компаниудын удирдлагад өөрчлөлт орж Ард Кредитын Гүйцэтгэх захирлаар Гэрэлтийн Тэлмэн, Ард Лайфын гүйцэтгэх захирлаар Булганы Гантулга нар шинээр томилогдлоо.

Тэлмэн нь БНСУ-ын LG гадаад дотоодын худалдаа, хөрөнгө оруулалтын компаниудад менежментийн болон гүйцэтгэх удирдлагын түвшинд 10 гаруй жил ажилласан туршлагатай. 2016 онд Монгол Шуудан ХК-ийн хувьчлалын дараа компанийн Стратеги төлөвлөлт, бизнес хөгжлийг хариуцсан дэд захирлаар томилогдож 3 жилийн дотор компанийн

ашигт үйл ажиллагааг 15 дахин нэмэгдүүлж, логистикийн үйл ажиллагааг бүс нутгийн хэмжээнд тэлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн нэгэн юм.

Гантулга нь эдийн засагч мэргэжилтэй, банк, санхүү, гадаад худалдаа, уул уурхай, хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, финтек, хөрөнгийн бирж, санхүүгийн зах зээл дээр ажилласан өргөн хүрээний туршлагатай мэргэжилтэн бөгөөд Лендмн ХК, Сүү ХК, АНАКС ХХК-д гүйцэтгэх захирлаар, Моннис группд дэд захирлаар, ХасБанканд Маркетинг хариуцсан дэд захирлаар тус тус ажиллаж байсан. Тэрээр Плехановын нэрэмжит ОХУ-ын эдийн засгийн академийг эдийн засагч мэргэжлээр улаан дипломтой төгссөн.

Бид ажилтнуудынхаа хөрөнгө оруулалтын компани болох EIT-ээр дамжуулан жил бүр хувьцаа эзэмших эрхийг нийт ажилчдадаа санал болгоод 3 жил болжээ. Энэ жилээс компанийнхаа ашиг шим болох 400 сая төгрөгийн ногдол ашгийг мөн хуваарилав.

Мөн 2019 оны урамшуулал болгон Ард Даатгал, Ард Кредит, Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцаа, Ард Лайф хувийн тэтгэврийн данс, АрдКойноор тэнцүү хуваан нийт ажилтнууддаа урамшуулал олголоо. Бид өнгөрсөн оны гүйцэтгэл дээр тулгуурлан ТУЗ-ийн гишүүдэд 195 сая төгрөгтэй тэнцэх, удирдлага болон ажиллагсдад 563 сая төгрөгтэй тэнцэх урамшуулал олгосныг дуулгахад таатай байна.

Бид багаа хамгийн чадварлаг, авьяаслаг залуусаар бүрдүүлэхийг эрмэлзэж ирсэн бөгөөд тэд маань санхүүгийн асуудлаа бүрэн шийдсэн байх ёстой гэх философийг хэлбэрэлтгүй мөрдөж ирсэн юм.

## Технологи

2019 онд бид Ард Апп болон суурь системийн дэд бүтцийг хөгжүүлэх тал дээр анхаарал хандуулан ажилласан болно. Ард Аппын 3.0 хувилбарыг шинээр нэвтрүүлж, дизайныг мэргэжлийн багийн тусламжтайгаар шинэчлэн хялбар болгосон бөгөөд шинэ нэмэлт функц болон сайжруулалтыг хийж гүйцэтгэв.

Ард Апп дээр нэмэгдсэн шинэ функцийн хувьд: Ард Лайфын шинэ данс нээх буюу харилцагчид салбар дээр ирэхгүйгээр хувийн тэтгэврийн хуримтлалаа нээх боломжийг бүрдүүлэв. Ард Секюритизийн хувьд манай харилцагчид өөрийн үнэт цаасны дансаа нээх болон хөрөнгийн биржийн хувьцааны арилжаанд оролцох боломжтой болов. Өөрт ойрхон АТМ-ын байршил харуулах мөн картгүйгээр АТМ-ээс бэлэн мөнгө авах функц апп дээр мөн нэмэгдсэн. Заавал QR код үүсгэж явуулах шаардлагагүйгээр харилцах дансаа бусад банкны аппаар цэнэглэх боломжтой болж, Аппын хэрэглэгч ашиглахад хялбар болов. Ард Аппд бусад олон шинэ үйлдэл нэвтрүүлснээс онцолбол:

Онлайн цалингийн зээлийн бүтээгдэхүүн нэвтэрснээр зээлийн үнэлгээг автоматаар хийх, цалингийн зээлийг онлайнаар олгох боломж бүрдсэн;

Зээл хаах гүйлгээ нэмэгдсэнээр харилцагч өөрийн хүссэн хуваарийн дагуу зээлээ эргэн төлөх, хаах боломжтой болсон;

Захиалгат гүйлгээ нэвтэрснээр хэрэглэгч өөрийн сонгосон интервал, үнийн дүнгээр хуримтлалдаа тогтмол орлого хийх боломж бүрдсэн;

Кино театрын тасалбар худалдан авах үйлдэл нэмэгдсэнээр хэрэглэгч урт дараалалд зогсохгүйгээр Апп дотроосоо кино болон суудлаа сонгож тасалбар авах боломжтой болсон;

Биллинг үйлчилгээ нэмэгдсэнээр хэрэглэгч СӨХ, орон сууц, интернет болон бусад хэрэглээний төлбөрөө төлөх боломжтой болсон байна.

Мөн манай суурь систем бөгөөд дэд бүтцэд хөгжүүлэлт сайжруулалтууд хийгдсэн: зах зээл дээрх шилдэг BI Хэрэгсэл болох – Tableau-г өгөгдөл дээр илүү сайн ажиллах мөн эцсийн харилцагчид тохирох бүтээгдэхүүн санал болгох үүднээс Ард Санхүүгийн Нэгдэл болон охин компаниудад нэвтрүүлсэн. Манай суурь банкны дэд бүтэц шинэчлэгдэж, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээнүүдийг авсан бөгөөд мөн системийн хадгалалт болон систем хянах платформуудыг нэвтрүүлсэн болно.

## Хөрөнгө оруулалт

### Ард Лайф

Хувийн тэтгэврийн сангийн хууль, журмын төсөл боловсруулагдаж эхэлсэнтэй холбоотойгоор ирээдүйн дүрмийн сангийн болзошгүй шаардлагад нийцүүлэх зорилгоор Ард Санхүүгийн Нэгдэл нь 14 тэрбум төгрөгийн үнэлгээтэй үл хөдлөх хөрөнгө, компанийн хувьцааг Ард Лайф руу шилжүүлж Ард Лайфын өөрийн хөрөнгийг 9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ. Энэхүү капиталжуулалт нь тэтгэврийн данс эзэмшигчдийн эрсдэлийг бууруулах, хөрөнгө оруулалтын багцыг төрөлжүүлэх, урт хугацааны тогтвортой үнэ цэнэ үүсгэх зэрэг давуу талуудыг бий болгож байна.



### Хөрөнгийн жагсаалт

**20%** Үл хөдлөх (Номын Хишигийн 20 хувь болон бусад үл хөдлөх)

**4%** Техник Технологийн Коллежийн 4 хувь

**3.6%** Монгол Шуудангийн 3.6 хувь

### Энэ хэлцлийн үр дүнд:

Ард Санхүүгийн Нэгдэл урт хугацааны хөрөнгө оруулалтаасаа зарж ашиг хийсэн

Тэтгэврийн санд хувь эзэмшигчдийн эрсдэл буурсан

Ард Лайфын багцыг төрөлжүүлсэн



## Монгол Шуудан

Ард Санхүүгийн Нэгдэл нь Монгол Шууданд эзлэх хувиа 3.61 хувиар нэмэгдүүлж нийт 31.4 хувь болгосон. Монгол Шуудангийн дэд бүтэц болох 391 салбарыг ашиглаж Ард Санхүүгийн Нэгдлийн компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах, хүргэлтийн үйлчилгээ үзүүлэх, улмаар банкны үйлчилгээ эхлүүлэх төлөвлөгөөний хүрээнд ирээдүйд эзэмших хувиа үргэлжлүүлэн нэмэгдүүлэх болно.



## Ард Шоп

2018 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын гэрээний хүрээнд бид MEC Partners-д сар бүр 20 сая төгрөгийг Ард Шопын хөгжүүлэлтийн төлбөрт төлдөг. Нийт 480 сая төгрөг төлөгдөх бөгөөд Ард Холдингс Ард Шопын 40 хувийн эзэмшигч болно.

## Монголын Хөрөнгийн Биржийн арилжаа

Ард Санхүүгийн Нэгдэлийн компаниуд хувьцааныхаа үнийг дэмжих бодлого хэрэгжүүлдэг бөгөөд зах зээлийн үнэ бодит үнэ цэнээс хямд байгаа тохиолдолд хувьцаагаа нээлттэй захаас худалдаж авдаг.

2019 онд Ард Санхүүгийн Нэгдлийн компаниуд Монголын Хөрөнгийн Бирж дээр Ард Даатгалын 5.25 хувийг 927 саяаар, Ард Кредитын 5.74 хувийг 1.2 тэрбумаар, Ард Санхүүгийн Нэгдлийн 2.3 хувийг 1.09 тэрбумаар, Монгол Шуудангийн 0.46 хувийг 271 саяаар тус тус худалдан авч нийтдээ 3.5 тэрбум төгрөгийн арилжаа хийжээ.



### Ард Холдингс Интернэйшнл

Арилжааны банкны хувьцаа худалдан авах зорилгоор Ард Санхүүгийн Нэгдэл Ард Холдингс Интернэйшнл компанийг үүсгэн байгуулж өөрийн хувьцааныхаа 15 хувийг шилжүүлэн хөрөнгө босгох ажлыг эхлүүлсэн.

### Ард Бит Глобал

Ардын урамшууллын хөтөлбөр болох АрдКойн нь блокчэйн технологи дээр суурилсан бөгөөд энэхүү технологийн хууль, эрх зүйн зохицуулалт Монгол Улсад боловсруулагдаагүй байна. Тиймээс дэлхий дээр блокчэйн технологийн салбарт хамгийн урд алхаж байгаа орнуудын нэг болох Сингапурт Ард Бит Глобал компанийг үүсгэн байгуулах ажлыг эхлүүлсэн.

## Өөрийн хувьцааг авах

Ард Санхүүгийн Нэгдэл нь нээлттэй болж Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдахаас өмнө хувьцаагаа охин компани дээрээ эргүүлэн худалдаж авах хоёр гэрээ хийсэн байсан бөгөөд тус хоёр гэрээний хэрэгжилтийн хүрээнд нийт 420 мянган евро болон 500 сая төгрөгийн төлбөрийг гүйцэтгэсэн байна.

Хувьцаа эзэмшигч Гэрэлтуяагаас 500 сая төгрөгт, Венчурс Уан Сангаас 420,000 еврогоор (4 хувааж төлөх) хэлцлүүд хийж, хувьцаагаа нээлттэй болохоос өмнө буцаан худалдаж авсан.



## Санхүүгийн гүйцэтгэл

2019 онд Ард Санхүүгийн Нэгдлийн хөрөнгө 78.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 29.1 хувиар буюу 17.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтийг бидний хөрөнгө оруулалтын багцын дахин үнэлгээний өсөлт болох 16.1 тэрбум төгрөг хангасан бөгөөд үүн дотор Ард Кредитын IPO-ны улмаас манай хөрөнгө оруулалтын багцын үнэлгээ 8.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Үүний хажуугаар манай баланс дээрх авлага болон бусдад олгосон зээлийн багц 4.5 тэрбум төгрөгөөр буурч 5.3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин борлуулах зорилгоор эзэмшиж буй болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үлдэгдэл 4.8 тэрбум төгрөгийг данснаас бүрэн хасаж Ард Лайф ХХК хөрөнгө оруулалт хийгдсэн. Тайлант хугацааны хөрөнгийн өсөлтийн санхүүжилтийг 11.5 тэрбум төгрөгийн өр төлбөрөөр, 6.0 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгийн өсөлтөөр бүрдүүлсэн байна.

Нийт өр төлбөр 10.0 тэрбум төгрөгөөс 21.5 тэрбум төгрөг болж, жилийн хугацаанд 11.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үйл ажиллагаагаа тэлэх, эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх, нэмэлт хөрөнгө оруулалт хийх зорилгоор нийт 6.6 тэрбум төгрөгтэй тэнцэх компанийн бонд гаргасан нь өр төлбөр нэмэгдэх гол хүчин зүйл болов. Тайлант хугацаанд нийт 1.5 тэрбум төгрөгийн хүүний болон купоны зардал төлснөөр бидний эх үүсвэрийн дундаж өртөг 6.78 хувь болсон байна. Мөн бидний хөрөнгө оруулалтын үнэ цэнэ өсөхтэй холбоотойгоор хойшлогдсон татварын өглөг 1.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 3.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Өөрийн хөрөнгө буюу эздийн өмч 50.5 тэрбум төгрөгөөс 12.0 хувиар буюу 6.1 тэрбум төгрөгөөр өсч, 56.6 тэрбум төгрөгт хүрэв. Ингэснээр манай хувьцааны дотоод үнэлгээ 2,195 төгрөгт хүрэв.



2018 онд нийт өр төлбөр нийт хөрөнгийн 16.5 хувийг эзэлж байсан бол 2019 онд энэхүү харьцаа нь 11.0 пунктээр нэмэгдэж 27.5 хувь болсон байна.

Харин нийт өр төлбөр болон өөрийн хөрөнгийн харьцаа 2018 онд 19.7 хувь байснаас 2019 онд 38.9 хувь болж, 19.2 пунктээр нэмэгдсэн байна.



2019 онд нийт үйл ажиллагааны орлого 11.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 6.5 тэрбум төгрөгөөр буюу 125 хувиар өссөн байна. Бид Ард Даатгал болон Монгол Шуудан зэрэг компаниудаас нийтдээ 537.2 сая төгрөгийн ногдол ашгийг хүлээн авсан бөгөөд энэ нь өмнөх жилийн ногдол ашгийн орлогоос 360.5 сая төгрөгөөр бага байсан нь Ард Кредит IPO хийсэнтэй холбоотойгоор 2018 оны цэвэр ашгаасаа ногдол ашиг олгоогүйтэй холбоотой. Мөн бидний үйл ажиллагаа өргөжиж, олон нийтэд хүрч ажиллах цар хүрээ нэмэгдэж, санхүүгийн эх үүсвэрийн зардал нэмэгдсэнтэй

холбоотойгоор нийт зардал 4.5 тэрбум төгрөгөөс 7.3 тэрбум төгрөг болж өссөн байна. Зардлын харьцааг дурдвал цалингийн зардал нийт зардлын 15.8 хувийг эзэлснээр 4.9 пунктээр буурсан бол үйл ажиллагааны зардал нийт хөрөнгийн 6 хувьтай тэнцсэнээр 1.5 пунктээр нэмэгдсэн байна.

Тайлант жилд бид үйл ажиллагаанаасаа 3.4 тэрбум төгрөгийн цэвэр ашгийг үйлдвэрлэсэн бөгөөд энэ нь 2018 оны үзүүлэлт болох 667 сая төгрөгөөс 410 хувиар их байна. Харин хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлтийг багтаасан нийт дэлгэрэнгүй орлого нь тайлант хугацааны эцэст 5.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилээс 2.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

# Хөрөнгө оруулалтын багц

## Санхүү



- Ард Санхүүгийн Нэгдэл
- Холбоотой талууд
-  Нээлттэй компани

## Бусад



100%



40%

## Дэд бүтэц



25.5%

5.9%



100%



20%

### 2019 оны онцлох үйл явдал

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2019 оны 4 сард хуралдуулан компанийн ТУЗ-ийн сонгуулийг явуулж, шинээр И.Сэр-Од хараат бус гишүүнээр сонгогдов.

2018 оны цэвэр ашгаас 50 хувийг нь ногдол ашгаар хуваарилахаар шийдвэрлэж, 6 сард ногдол ашгийг нийт хувьцаа эзэмшигчдэд хуваариллаа.

Эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг шинэчилж, борлуулалтыг эхлүүлэв.

Даатгалын бүтээгдэхүүний борлуулалтыг Инсур програмаар дамжуулан хийж эхэллээ. Хөрөнгө Оруулагч Үндэстэн чуулга уулзалтын ерөнхий ивээн тэтгэгчээр оролцож, Монгол HD телевизээр үзэгчдэд хүрсэн дэлхийн хэмжээний Интернетийн эсрэг Эмч нар шоу нэвтрүүлгийн ивээн тэтгэгчээр ажиллав.

Төлөвлөгөө гүйцэтгэлээр шалгарсан аймаг орон нутгийн зарим салбарууд болон нөхөн төлбөрийн шуурхай албанд шинээр автомашин худалдан авлаа.

### Үйл ажиллагааны тайлан

Ард Даатгал ХК нь 2019 оныг 11.8 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй, нийт 20.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй үдлээ. 2019 оны эцсээр хураамжийн орлого 11.4 тэрбум төгрөг байсан ба үүнээс цэвэр хураамжийн орлого 8.9 тэрбум төгрөг хүрсэн байна. 2019 онд бид 5,152 даатгуулагчийн 4.4 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж, даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүллээ. Тайлант хугацаанд манай компани давхар даатгалын компаниудтай амжилттай хамтран ажиллаж нийт хохирлын 10 хувь буюу 451 сая төгрөгийг давхар даатгагчаар төлүүлж, үлдэх хэсгийг өөрийн нөөц сангаас төлсөн. Олгосон нөхөн төлбөрийн дүн 2018 онтой харьцуулахад 26 хувиар буурсан байна.

Компанийн цэвэр ашиг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал 36 хувийн өсөлт үзүүлж 1.7 тэрбум төгрөг хүрч нэгж хувьцаанд ногдох ашиг 69 төгрөг, өөрийн хөрөнгийн өгөөж 15.1 хувьд хүрсэн байна. Бид 2019 онд хөрөнгө оруулалтаас 2.4 тэрбум төгрөгийн орлого олсон бөгөөд өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд нийт 15.5 тэрбум төгрөгийг 11.2 хувийн жигнэсэн дундаж өгөөжтэйгээр байршуулан ажиллалаа. Банкны хугацаатай хадгаламж, банк бус санхүүгийн

байгууллагын итгэлцэл, компанийн бонд болон МХБ-ийн нэг, хоёрдугаар зэрэглэлийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийжээ.

2019 оны эцсээр компанийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт 123.15 хувьтай байсан ба хохирлын харьцаа 41.1 хувь, зардлын харьцаа 62.6 хувь, хосолсон харьцаа 103.7 хувьтай гарчээ. Компани даатгалын борлуулалтыг банк, банк бус санхүүгийн байгууллагууд, даатгалын зууч компани, төлөөлөгчдөөр дамжуулан хийдэг бөгөөд нийт 4 банк, 25 банк бус санхүүгийн байгууллага, 20 зууч компаниудтай хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байна. Даатгалын зуучлалаар бид нийт 3.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулбал 14 орчим хувийн өсөлт үзүүлсэн байна.

Ард Даатгал ХК нь 2019 оны жилийн эцсийн байдлаар даатгалын салбарт мэргэшсэн туршлагатай 99 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 45 хувь нь орон нутагт ажиллаж байна.

## Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



| Тикер | Нээлт | Дээд | Доод | Хаалт | Өөрчлөлт | Хугацаа    | Өдрийн дундаж арилжаа | Нийт арилжаа  |
|-------|-------|------|------|-------|----------|------------|-----------------------|---------------|
| AIC   | 730   | 800  | 599  | 800   | 9.6%     | IPO        | 16,436,242            | 4,667,892,671 |
|       |       |      |      |       |          | Оны эхнээс | 9,849,709             | 2,176,785,588 |
|       |       |      |      |       |          | Q4         | 10,524,632            | 620,953,286   |

52 долоо хоног (2019)

Нийт хувьцааны тоо

Зах зээлийн үнэлгээ

Нийт арилжааны дүн

₮599 - ₮800

25,000,000.0

₮19,999,750,000.0

₮2,176,785,588.0

Хаалтын үнэ

₮800.0

Дансны үнэ

₮472.2


P/E - Үнэ/Ашиг

11.6


P/B - Үнэ/Дансны үнэ

1.7


### Нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгө (сая төгрөг)




### Нийт хураамжийн орлого (сая төгрөг)




### Нийт нөхөн төлбөр (сая төгрөг)




### Хөрөнгө оруулалтын орлого (сая төгрөг)



### Цэвэр ашиг (сая төгрөг)



### Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөг)



### 2019 оны онцлох үйл явдал

Үнэт цаасаа олон нийтэд нээлттэй санал болгож, Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй олон нийтэд нээлттэй хувьцаат компани болов.

Ард Апп-ын 3.0 хувилбарыг олон нийтэд танилцуулав.

Япон улсын Крауд Кредит хөрөнгө оруулалтын сантай хамтын ажиллагааны хүрээнд тайлант онд нийт 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хүлээн авав.

Хувьцаат компани болсны дараах анхны хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2019 оны 4 сарын 27-ны өдөр 81 хувийн ирцтэй амжилттай зохион байгуулав.

### Үйл ажиллагааны тайлан

Бид 2019 онд үндсэн бүртгэлийн системээ шинэчлэн, дэвшилтэд технологи дээр суурилсан санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэгч Ард Аппыг зах зээлд амжилттай нэвтрүүлэн харилцагчдынхаа богино хугацааны санхүүгийн хэрэгцээг түргэн шуурхай шийдвэрлэн, уламжлалт зээлийн үйл ажиллагааг илүү хялбаршууллаа. Монгол Шуудан ХК-тай стратегийн түншлэлийн гэрээ байгуулснаар Монгол Шуудангийн салбаруудаар дамжуулан санхүүгийн үйлчилгээг Монгол орны өнцөг булан бүрт хүргэн, харилцагчдад хамгийн ойр, түргэн шуурхай хүрч ажиллаж эхэлсэн байна. 2019 онд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 120 хувиар өсч 23.1 тэрбум төгрөгт, цэвэр зээлийн багцын хэмжээ 141.5 хувиар өсч 18.0 тэрбум төгрөгт хүрэн нийт 2.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Энэ нь дундаж өөрийн хөрөнгийн өгөөжийг 24.8 хувьд хүргэв.

Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө өмнөх оноос 76 хувиар өсч 10.8 тэрбум төгрөгт хүрсэн нь итгэлцлийн үйлчилгээ 5.4 тэрбум төгрөг, олон улсын санхүүжилт 2.4 тэрбум төгрөг, Санхүүгийн

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Бичил Санхүүгийн Төвийн 2019 оны хуралд Алтан спонсороор баг, хамт олноороо амжилттай оролцон Ард Апп-ыг гадны хөрөнгө оруулагчдад танилцуулав.

Монголбанкны Төлбөр тооцооны газарт Цахим мөнгөний тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргав.

Харилцагчийн төлбөр тооцооны үйл ажиллагааг түргэн шуурхай бүртгэх үүднээс төлбөр тооцооны COT системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүллээ.

Зохицуулах Хорооны зөвшөөрөлтэй хаалттай бондын 1.9 тэрбум төгрөгөөс бүрдэж байна.

Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ 3.7 тэрбум төгрөгөөс 10.7 тэрбум төгрөгт хүрч 7.0 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд энэхүү өсөлт нь Монголын Хөрөнгийн бирж дээр IPO амжилттай хийж 5.2 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой юм. 2019 онд нийт харилцагчийн тоо өмнөх оноос 19,404 хувиар өсч 200.5 мянгад хүрч нийт 76,273 иргэн, аж ахуйн нэгжид 42.8 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд нийт зээлийн багц өмнөх оноос 140 хувиар буюу 10.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Зээл олголтын 88 хувийг Ард Апп-д суурилсан Fast Cash зээлийн бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд зээлийн бүтээгдэхүүний хувьд эрэлт өндөртэй, дэвшилтэт технологи дээр суурилсан санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн болж чадлаа.

Ард Аппын хэрэглэгчдийн тоо эрчимтэй өсч, компанийн цар хүрээ тэлэн бүтээгдэхүүн үйлчилгээ шинэчлэгдэхийн хэрээр харилцагч бүрт хүрч үйлчлэх зорилгоор Харилцагчийн Үйлчилгээний Төвийг нийт 20 гаруй ажилтантайгаар байгуулан

CallPro ХХК-тай хамтран ажиллаж эхэллээ. Бид Ард Аппаар дамжуулан Монгол Улсын хаана ч зөвхөн QR код уншуулан бүх төрлийн төлбөр тооцоог хийх боломжийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Бид 2019 оны жилийн эцсийн байдлаар 40 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байгаа

бөгөөд нийт ажиллагсдын 50 гаруй хувь нь Харилцагчийн Үйлчилгээний Төвд ажиллаж байна. Ард Кредит ББСБ нь ХК болж 3 сарын 12-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант он дуустал нийт 34.7 сая ширхэг хувьцаа 2.74 тэрбум төгрөгийн дүнтэй арилжаалагдлаа.

| Тикер | Нээлт | Дээд  | Доод | Хаалт | Өөрчлөлт | Хугацаа | Өдрийн дундаж арилжаа | Нийт арилжаа  |
|-------|-------|-------|------|-------|----------|---------|-----------------------|---------------|
| ADB   | 81    | 93.15 | 64.5 | 81.97 | 1%       | 2019    | 14,061,734            | 2,742,038,039 |

52 долоо хоног (2019)

Нийт хувьцааны тоо

Зах зээлийн үнэлгээ

Нийт арилжааны дүн

Хаалтын үнэ

Дансны үнэ

P/E - Үнэ/Ашиг

P/B - Үнэ/Дансны үнэ

₮64.5 - ₮93.15

280,000,000

₮22.06 тэрбум

₮2.74 тэрбум

₮81.97

₮38.8

9.29

2.02



Нийт хөрөнгө (сая төгрөг)

|      |             |        |
|------|-------------|--------|
| 2017 | <div></div> | 10,193 |
| 2018 | <div></div> | 10,472 |
| 2019 | <div></div> | 23,094 |

Зээлийн багц (сая төгрөг)

|      |             |        |
|------|-------------|--------|
| 2017 | <div></div> | 7,975  |
| 2018 | <div></div> | 7,596  |
| 2019 | <div></div> | 18,430 |

Цэвэр ашиг (сая төгрөг)

|      |             |       |
|------|-------------|-------|
| 2017 | <div></div> | 642   |
| 2018 | <div></div> | 342   |
| 2019 | <div></div> | 2,187 |

Эздийн өмч (сая төгрөг)

|      |             |        |
|------|-------------|--------|
| 2017 | <div></div> | 3,735  |
| 2018 | <div></div> | 3,757  |
| 2019 | <div></div> | 10,692 |

Хүү болон шимтгэлийн орлого (сая төгрөг)

|      |             |       |
|------|-------------|-------|
| 2017 | <div></div> | 1,858 |
| 2018 | <div></div> | 1,903 |
| 2019 | <div></div> | 5,916 |

Зээлдэгчдийн тоо

|      |             |        |
|------|-------------|--------|
| 2017 | <div></div> | 691    |
| 2018 | <div></div> | 1,028  |
| 2019 | <div></div> | 25,431 |

### 2019 оны онцлох үйл явдал

Ард Аппаар дамжуулан үнэт цаасны дансаа нээх, хувьцааны анхдагч болон хоёрдогч арилжаанд оролцох боломжийг нээв.

3 компанийн хаалттай хүрээнд гаргасан бондын андеррайтераар ажиллаж, нийт 11.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай босгов.

### Үйл ажиллагааны тайлан

2019 онд Ард Секюритиз ҮЦК нь Ард Кредит ББСБ ХК-ийн IPO-ны туслах андеррайтераар амжилттай оролцож нийт биелсэн захиалгын 40 хувь буюу 2.1 тэрбумыг 644 харилцагчаас татан төвлөрүүлжээ.

IPO-нд оролцсон харилцагчдын 43 хувь нь Ард Аппаар дамжуулан захиалгаа өгсөн нь хөрөнгийн зах зээлийн хувьд шинэлэг зүйл байлаа.

Хувьцааны анхдагч арилжаанд оролцохоос гадна харилцагч Ард Аппаараа үнэт цаасны дансаа нээх, МХБ дээр бүртгэлтэй бүхий л хувьцааг номинал дансны тусламжтайгаар авах, зарах, хувьцааны үлдэгдэл болон хуулгаа харах, зах зээлийн судалгаа шинжилгээтэй танилцах бүрэн боломжтой болжээ. Цаашилбал, харилцагч өөрийн хөрөнгө оруулалтын өгөөжөө тооцох, бондын захиалга өгөх, гадаад

Монголын Хөрөнгийн Бирж дээрх хоёрдогч зах зээлийн арилжааны дүнгээр тэргүүлэв.

арилжаанд оролцох боломжийг нээж өгөхөөр компани ажиллаж байна.

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголын Хөрөнгийн Биржээр анхдагч болон хоёрдогч зах зээлийн 133.5 тэрбум төгрөг, ЗГҮЦ-ны 9.7 тэрбум төгрөг, нийт 143.2 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Үүнээс 60.96 тэрбум төгрөгийн хувьцааны хоёрдогч арилжаа явснаас 12.7 тэрбум буюу нийт арилжааны 20.8 хувийг Ард Секюритиз ҮЦК дангаараа бүрдүүлж чаджээ.

Мөн андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд Ард Секюритиз ҮЦК нь хэд хэдэн компанид бизнес төлөвлөгөө, салбарын судалгааг хийж гүйцэтгэн, санхүүжилт татаж өгсөн ба танхимын сургалт, уулзалтуудыг амжилттайгаар зохион байгуулсаар ирлээ.

#### Харилцагчдын тоо

|      |  |        |
|------|--|--------|
| 2017 |  | 14,869 |
| 2018 |  | 59,432 |
| 2019 |  | 69,550 |

#### Нийт хөрөнгө (сая төгрөг)

|      |  |       |
|------|--|-------|
| 2017 |  | 3,489 |
| 2018 |  | 3,032 |
| 2019 |  | 3,119 |

#### Нийт орлого (сая төгрөг)

|      |  |     |
|------|--|-----|
| 2017 |  | 517 |
| 2018 |  | 976 |
| 2019 |  | 766 |

### 2019 оны онцлох үйл явдал

Үндсэн банкны системээ шинэчилж, үйлчилгээгээ Ард Аппаар авах боломжийг бүрдүүлэв.

Бүх гишүүдийн хурлаа 21 хувийн ирцтэйгээр 3 сард зохион байгууллаа.

Хадгаламж зээлийн хоршоо гишүүдийнхээ тоог 15 хувиар нэмэгдүүлж 732 гишүүнтэй болов.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 102 хувь нэмэгдүүлж 803 сая төгрөгт хүргэв.

### Үйл ажиллагааны тайлан

Ард Актив хадгаламж зээлийн хоршоо нь 2019 онд нийт хөрөнгөө 47 хувиар нэмэгдүүлж 4.1 тэрбум төгрөг, хувь нийлүүлсэн хөрөнгөө 102 хувиар нэмэгдүүлж 803 сая төгрөгт хүргэлээ. Нийт орлогоо 44 хувиар нэмэгдүүлж 699 сая төгрөгийн орлоготой, 37 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

2019 онд 2.5 тэрбум төгрөгийн хадгаламж шинээр татан төвлөрүүлж, 1.9 тэрбум төгрөгийн хугацаа дууссан хадгаламжийг гишүүддээ олгон 3.2 тэрбум төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлтэй байна.

2019 онд 3.2 тэрбум төгрөгийн зээлийг шинээр олгон, 2.3 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдэж цэвэр зээлийн үлдэгдэл 3.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Зээлийн сайн түүхтэй гишүүддээ хүү багатай зээл олгох бодлогыг баримтлан ажилласнаар чанаргүй зээлийн хувь хэмжээг салбарын дунджаас харьцангуй бага буюу 1.4 хувьд барьж ажилласан байна.

#### Нийт хөрөнгө (сая төгрөг)

|      |  |       |
|------|--|-------|
| 2017 |  | 9     |
| 2018 |  | 2,816 |
| 2019 |  | 4,142 |

#### Хадгаламж (сая төгрөг)

|      |  |       |
|------|--|-------|
| 2017 |  | 1,108 |
| 2018 |  | 2,170 |
| 2019 |  | 3,036 |

#### Зээл (сая төгрөг)

|      |  |       |
|------|--|-------|
| 2017 |  | 787   |
| 2018 |  | 2,227 |
| 2019 |  | 3,205 |

## Ард Лайф

### 2019 оны онцлох үйл явдал

Ард Апп дээрээсээ тэтгэврийн дансаа удирдах боломжийг олгов.

24 хувийн хөрөнгө оруулалтын өгөөжийг АрдКойноор хуваарилав.

Тэтгэврийн хуримтлалын шинэ багц бүтээгдэхүүн нэвтрүүлэв.

Хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэв.

### Үйл ажиллагааны тайлан

2019 он Ард Лайф ХХК-ийн хувьд удирдлагын өөрчлөлт хийж, шинийг эрэлхийлж, том зорилго урдаа тавьсан жил болж өнгөрлөө. “Тэтгэврийн тогтолцооны шинэчлэл” гэх сэдвийн хүрээнд бид иргэддээ тэтгэврийн хуримтлал үүсгэхийн ач холбогдлын талаар, хойч үедээ хуримтлал өвлүүлэн үлдээж Монгол хүн Монгол баялгийн эзэн суух талаар танилцуулга сургалтууд зохион байгуулж иргэдэд ирээдүйгээ баталгаажуулах түлхүүрийг гарт нь бариулах зорилготойгоор ажиллалаа.

2019 оны эхний улиралд бид 2018 оны хөрөнгө оруулалтын өгөөжийг 24 хувиар хуваарилах шийдвэр гаргаж түүнийгээ АрдКойноор хуваарилсан билээ. АрдКойны ханшийн үзүүлэлтээс хамаарснаар харилцагчид 96 хувийн бодит өгөөж хүртэж чадсаныг дурдах нь зүйтэй.

2019 оны сүүлийн улиралд Ард Лайф ХХК-д шинэ Гүйцэтгэх Захирал ажиллах болсноор компанийн үйл ажиллагаа идэвхжиж бид олон нийтэд болон улсын ба хувийн хэвшлийн байгууллагуудад танилцуулга хийж эхэллээ. Түүнчлэн бид 2019 оны 11 дүгээр сард тэтгэврийн хуримтлалын шинэ бүтээгдэхүүн олон нийтэд нэвтрүүлснээр 200 гаруй шинэ харилцагчдад хуримтлалын данс нээв. Хуримтлалын бүтээгдэхүүн нь өндөр үнэлгээ бүхий эрүүл мэнд гэнэтийн ослын даатгал хавсаргаж, урд өмнөөсөө өндөр өгөөж амладаг болсноор иргэд богино хугацаанд өндөр тэтгэвэр тогтоолгон тэтгэврийн нэмэлт эх үүсвэр бий болгох зорилготойгоор Ирээдүйгээ баталгаажуулж байна.

Ард Лайф нь хөрөнгө оруулалтын багцаа өргөжүүлж 2019 оны байдлаар нийт 17 компанийн хувьцаа

эзэмшиж байна. Бид Ард Санхүүгийн Нэгдэл ХК дахь эзэмшлээ өсгөж нийт 1,365,018 ширхэг хувьцаа эзэмшиж тус компанийн 4.77 хувийг, Ард Даатгал ХХК-ийн 4.6 хувийг, Ард Кредит ББСБ ХК-ийн 3.08 хувийг тус тус эзэмшиж байна. Мөн АрдКойнд нэмэлт хөрөнгө оруулснаар бидний харилцагчдаа өндөр хөрөнгө оруулалтын өгөөж олгох чадавхыг нэмэгдүүлсээр байна. Бид цаашид хөрөнгө оруулалтын багцаа төрөлжүүлж харилцагч нарын хуримтлалын дансны өгөөжийг хамгийн

өндөр түвшинд барьж ажиллахаар зорьж байна. 2019 оны онцлох үйл явдлуудын нэг бол Ард Лайфын хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн явдал байлаа. 2019 оны байдлаар Ард Лайф ХХК-ийн нийт дүрмийн сан 10,010,000,000 төгрөг болж компани нь үйл ажиллагаа өргөжүүлж, олон түмэндээ тэтгэврийн хуримтлал үүсгэх ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулахад бэлэн боллоо.

#### Хөрөнгө оруулалт (сая төгрөг)

|         |  |       |
|---------|--|-------|
| 2017 IV |  | 5,337 |
| 2018 IV |  | 1,806 |
| 2019 IV |  | 6,081 |

#### Нийт хөрөнгө (сая төгрөг)

|         |  |       |
|---------|--|-------|
| 2017 IV |  | 5,382 |
| 2018 IV |  | 2,582 |
| 2019 IV |  | 6,176 |

#### Тэтгэврийн хуримтлал (сая төгрөг)

|         |  |       |
|---------|--|-------|
| 2017 IV |  | 490   |
| 2018 IV |  | 927   |
| 2019 IV |  | 1,699 |

#### Хөрөнгө оруулалтын өгөөж (сая төгрөг)

|         |  |     |
|---------|--|-----|
| 2017 IV |  | 257 |
| 2018 IV |  | 102 |
| 2019 IV |  | 936 |

### 2019 оны онцлох үйл явдал

Монгол Улсын хамгийн анхны хамтын хөрөнгө оруулалтын сан болох Үндэсний Хувьчлалын Санг үүсгэн байгуулав.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг Жинст Увс ХК-тай нэгтгэх замаар компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулах ажлыг амжилттай гүйцэтгэхэд оролцов.

Ард Кредит ББСБ-ыг нээлттэй хувьцаат компани болж, Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэх ажлыг бусад мэргэжлийн оролцогчидтой хамтран амжилттай гүйцэтгэв.

Ард Холдингс Интернэшнл ХХК-йг үүсгэн байгуулахтай холбоотой үүсгэн байгуулах, хөрөнгө оруулалт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэв.

### Үйл ажиллагааны тайлан

2019 он Ард Менежмент компанийн хувьд төдийгүй Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хувьд онцлог жил байлаа. Учир нь Ард Менежмент нь Үндэсний Хувьчлалын Санг үүсгэн байгуулснаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлд зайлшгүй шаардлагатай байсан хамтын хөрөнгө оруулалтын санг бий болгох эхлэлийг тавилаа. Уг сан нь Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг төрийн оролцоотой компаниудын хувьчлалд оролцох, түүний бүтээж буй баялгаас хөрөнгө оруулагчдадаа хувь хүртээх зорилготой болно. Үндэсний Хувьчлалын Сан нь 2020 онд үйл ажиллагаа эхлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үйл ажиллагаа эхлүүлснээр хөрөнгийн зах зээлд үлэмж хэмжээний үнэт цаасны арилжааны идэвхийг бий болгоно гэж харж байна.

Мөн Ард Менежмент нь толгой компани болох Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон түүний хөрөнгө

оруулалттай компаниудын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр нэлээдгүй ажил гүйцэтгэн, 2019 оныг амжилттай үдлээ.

2019 онд Ард Менежментийн нийт хөрөнгө 378 сая төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 17 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэхүү өсөлтөд Үндэсний Хувьчлалын Санд хийсэн хөрөнгө оруулалт голлон нөлөөлсөн байна.

Мөн Ард Менежмент нь 258.9 сая төгрөгийн орлоготой, 257.9 сая төгрөгийн зардалтай ажилласан бөгөөд татварын дараах ашиг 0.9 сая төгрөг, нийт дэлгэрэнгүй ашиг 43.4 сая төгрөгт хүрсэн байна. Тайлант онд Ард Менежмент нь бүтэц, зохион байгуулалтаа өөрчилж, үндсэн үйл ажиллагаандаа төвлөрч ажилласан нь үндсэн бус үйл ажиллагааны орлого болон компанийн хүний нөөцийн зардлыг бууруулахад нөлөөлсөн байна.

#### Нийт хөрөнгө (сая төгрөг)

|      |     |
|------|-----|
| 2017 | 480 |
| 2018 | 322 |
| 2019 | 378 |

#### Урт хугацаат хөрөнгө оруулалт (сая төгрөг)

|      |     |
|------|-----|
| 2017 | 453 |
| 2018 | 217 |
| 2019 | 342 |

#### Нийт дэлгэрэнгүй ашиг (сая төгрөг)

|      |    |
|------|----|
| 2017 | 76 |
| 2018 | 68 |
| 2019 | 43 |

АрдКойн (ARDX) - ERC-20 блокчэйн дээр суурилсан инноваци бүхий урамшууллын оноо юм. АрдКойн нь супер Апп - Ард Санхүүгийн Нэгдлийн одоогийн дэд бүтэц дээр үндэслэсэн Ард Аппд холбогдсон юм. Ард Апп дээр банк, даатгал, үнэт цаасны арилжаа, хөрөнгө оруулалт, хувийн тэтгэврийн хуримтлал багтсан бөгөөд цахим худалдан авалт хүртэл хийх боломжтой. Төслийн гүйцэтгэл дээр "ICT Group" болон төлбөрийн шийдлийн программ хангамж боловсруулалтаар улсдаа тэргүүлэгч "Grape City Mongolia"-ийн Монгол хөгжүүлэгчид хамтран ажилласан юм.

АрдКойн нь Ард Апп-д харилцагчдыг идэвхжүүлэх гол хэрэгсэл болж чадсан бөгөөд 2019 оны эцэст 193,154 эзэмшигчтэй болов. Ард Санхүүгийн Нэгдлийн охин компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээнд урамшуулал болгож өгч байгаа явдал нь огтлолцоо борлуулалтыг өсгөхөд хувь нэмэр оруулж мөн үнэнч харилцагчдыг урамшуулах гол хэрэгсэл болсон юм. Ард Санхүүгийн Нэгдлээс АрдКойноор борлуулсан сугалаанд цоо шинэ Renault Kaptur машиныг харилцагчдадаа өгсөн бөгөөд 2020 онд 2 өрөө байрны болзолтой сугалаа мөн явагдаж байна.

АрдКойн нь криптовалютын хамгийн нэр хүндтэй олон улсын криптовалютын платформууд болох CoinMarketCap, LiveCoinWatch болон Blockfolio дээр платформ дээр бүртгэгдсэн Монголын хамгийн анхны криптовалют болж чадсан ба АрдКойныг дэлхийн хамгийн том криптовалютын платформоос олж харан, хянах боломжтой болсон.

АрдКойны бусад урамшууллын онооноос ялгарах нэг онцлог нь шууд төгрөгт хөрвөх боломжтой юм. Төгрөгөөр хамгийн идэвхтэй арилжаа Трейд.мн бирж дээр хийгдэж 2019 оны 4 сарын 18-ны өдрөөс 12 сарын 31-ний өдөр хүртэл нийт 2 тэрбум гаруй төгрөгийн арилжаа хийгджээ.

## 2019 оны онцлох үйл явдал

21 аймагт захиалга шууд хүргэдэг болов.

Гадаад шууд захиалгын платформ холболт амжилттай хийгдэж дуусав.

АрдШоп mobile 2.0 хувилбар амжилттай шинэчлэгдэв.

Бүртгэлтэй хэрэглэгчийн тоо 110'000 болов. Идэвхтэй мерчантын тоо 450 боллоо.

## Үйл ажиллагааны тайлан

Онлайн худалдаа олон улсад хөгжөөд 20 гаруй жил болж байгаа ч Монгол Улсад хэрэглээний хувьд шинэ салбар хэвээр байгаа бөгөөд онлайн худалдаанд оролцогч талуудыг сургах нь үйл ажиллагааны гол чиглэл хэвээр байна. АрдШопын хувьд 2019 онд үйл ажиллагаагаа сургах, хөгжүүлэх гэсэн чиглэлээр хуваан төвлөрч ажиллалаа.


Онлайн худалдаа ашиглах болон онлайн дэлгүүрээ ажиллуулах чиглэлээр Мерчантуудад нийт 50 орчим том жижиг сургалтуудыг хийж явуулсан байна. Үүний үр дүнд 30 мерчантын 500-аад нэр төрлийн бараа бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэж цаашид илүү гүнзгийрүүлэн хөгжүүлж ажиллахаар хамтын ажиллагааны төлөвлөгөө гаргаад байна.

Технологийн хөгжүүлэлтийн хүрээнд онлайн худалдааны эко систем болох борлуулагч, худалдан авагч, төлбөрийн хэрэгсэл, хүргэлт гэсэн хэсгүүдийг амжилттай холбож нэгэн цогц системийг хөгжүүлэн сайжруулах хэд хэдэн томоохон ажлуудыг хийж дуусгалаа. Мөн гадаадаас шууд захиалга хийх холболтыг Монголдоо анх удаа бие дааж амжилттай хийж дуусгасан бөгөөд энэ ажлын үр дүнд Монголоос Хятадын үйлдвэрлэгчдийн 54'000 нэр төрлийн барааг хамгийн хямд зардлаар захиалаад хүссэн газраа хүргүүлээд авах боломжтой болсон юм.

### Нийт захиалга



### Нийт хэрэглэгч



## Монгол Шуудан

### 2019 оны онцлох үйл явдал

Дотоод шуудангийн ялган боловсруулах төвийг шинээр байгууллаа.

ХУР системтэй холбогдож төрийн цахим үйлчилгээний нэгдсэн төвийг Монгол улсын бүх суманд нэвтрүүлж эхэллээ.

Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний систем болох Еврожайрод нэгдэн орсон.

Оросын шуудантай “Эрдэс баялгийн бус экспорт, импортыг дэмжих шуудангийн логистикийг хөгжүүлэх Стратегийн Хамтын Ажиллагааны Гэрээ” байгууллаа.

### Үйл ажиллагааны тайлан

Монгол Шуудан нь жил бүр хүний нөөцөө тогтмол нэмэгдүүлж 2019 оны эцсийн байдлаар нийт 925 ажилтантай болсон байна. Үүнээс 495 нь хөдөө орон нутагт, 430 нь Улаанбаатар хотын салбаруудад ажиллаж байна.

Улс хоорондын шуудангийн сүлжээний ашиглалтыг тасралтгүй, найдвартай хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд хүргэлтийг сайжруулах, тээврийн маршрутыг оновчлох, хүргэлтийн саатлыг бууруулах, илгээмжийн бүртгэлийг сайжруулах, технологийн процессыг шинэчлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.

Мөн үйлчилгээний чанарыг сайжруулах, хяналт тавих нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор 2019 оны 9 сараас эхлэн Дэлхийн Шуудангийн Холбооноос хэрэгжүүлж буй “Data Compliance” төсөлд нэгдэн нийт 10 төрлийн тайлан авч, тайлангаар ирүүлсэн алдаа дутагдлыг засаж сайжруулан чанарын үзүүлэлтийг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Орох, гарах чиглэлд 180,418 ширхэг буюу 1.6 тонн шуудан ялган боловсруулж, хүргэлээ. Илгээмж тус бүрээр задалбал, буухиа шуудан 129.0 мянган ширхэг, бичиг захидал 1.7 сая ширхэг, илгээлт

18.0 мянган ширхэг, хэвлэл 4.9 сая ширхэг тус тус ялган боловсруулж, хүргэжээ. Сааталтай хүргэгдсэн шуудангийн илгээмжийн тоо хэмжээ нь нийт солилцооны 0.033 хувийг эзэлж байгаа бөгөөд бүх нийтийн үйлчилгээний чанарын саатлын үзүүлэлтийн зөвшөөрөгдсөн хэмжээнд байна. 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Оросын Шуудан ТӨҮГ-тай гэрээ байгуулж, БНХАУ-аас ОХУ-руу чиглэсэн шуудан илгээмжийг Монгол улсаар дамжуулан өнгөрүүлэх хамтын ажиллагааг дахин эхлүүлэв. Ингэснээр автомашинаар гүйцэтгэсэн

транзит тээврийн нийт тоо 155 болж, нийт 1.1 мянган тонн 14.4 сая ширхэг транзит шууданг дамжуулан өнгөрүүлсэн байна.

Хот доторх гараас гарт хүргэлтийн үйлчилгээг сайжруулах, хурдасгах зорилгоор шинэ автомашин авч, хүргэлтийн бүтцийг хялбарчилж, үйлчилгээний систем, хүргэгчийн аппыг нэвтрүүлсэн бөгөөд орон нутгийн дайврын хот доторх хүргэлтийн үйлчилгээг эхлүүлсэн.

#### Нийт солилцоо

|      |                                                                                     |           |
|------|-------------------------------------------------------------------------------------|-----------|
| 2015 |  | 1,610,819 |
| 2016 |  | 1,571,830 |
| 2017 |  | 1,757,660 |
| 2018 |  | 2,302,599 |
| 2019 |  | 2,653,661 |

(2019 онд өмнөх жилээс 15.25 хувиар өссөн)

#### Нийт орлого (сая төгрөг)

|      |                                                                                      |           |
|------|--------------------------------------------------------------------------------------|-----------|
| 2015 |  | 10,094.19 |
| 2016 |  | 11,923.10 |
| 2017 |  | 13,627.63 |
| 2018 |  | 15,473.96 |
| 2019 |  | 16,725.01 |

#### Татварын дараах цэвэр ашиг (сая төгрөг)

|      |                                                                                     |          |
|------|-------------------------------------------------------------------------------------|----------|
| 2015 |  | 94.01    |
| 2016 |  | 1,006.58 |
| 2017 |  | 1,224.16 |
| 2018 |  | 1,560.27 |
| 2019 |  | 1,103.56 |



## Бидний ойрын ирээдүй

Манай багийн хувьд 2000 оноос эхлэн хэлбэрэлтгүй хөөцөлдсөн тэтгэврийн салбарын реформыг Монгол Улсад гүйцэлдүүлэх ажилд идэвхтэй байр сууринаас хандаж ажилласан бөгөөд 2007 оноос хойш хөгжүүлсэн хувийн тэтгэврийн Ард Лайф компанидаа шинээр гарах хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авах, шинэ стратегийн хөрөнгө оруулагчдыг татан оруулж ирэх, олон нийтэд хувьцааг нь санал болгох зэрэг ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Бид өмнө нь мэдэгдэж байсны дагуу даатгалын зах зээл дээрх нэгдэл, нийлэх боломжийг эрэлхийлэх бөгөөд амьдралын буюу урт хугацаат даатгалын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг Нэгдлийн бүрэлдэхүүнд оруулах тал дээр ахиц гарган ажиллаж байна.

Ард Кредитын хувьд Монголбанкнаас цахим мөнгөний тусгай зөвшөөрлөө авах ажлыг гүйцэлдүүлж, орон даяар хэрэгжих төлбөр тооцооны төгс шийдлийг гаргаж ажиллах юм. Манайхаас зээл авах боломжийг бид хөдөө орон нутгийн иргэдэд нээхээс гадна Ард Аппынхаа хамрах хүрээнд гадаадад суугаа Монголчуудаа хамруулж ажиллана.

Банкны салбарт явагдах реформын хүрээнд бидэнд илүү их боломж нээгдэнэ гэж бид харж байгаа бөгөөд арилжааны банк буюу банкны нэгдэлтэй хамтын ажиллагааны түншлэлийг үүсгэж, харилцан ашигтай бизнесийн загварыг санаачилж ажиллана.


Энэ хамтын ажиллагааны хүрээнд харилцан хөрөнгө оруулалт хийж, олон түмний оролцоотой банктай болох ажлыг бодитоор эхлүүлнэ. Бид нээлттэй бондоо Монголын зах зээл дээр анхлан гаргах, анхны хөрөнгө оруулалтын сангийнхаа үйл ажиллагааг эхлүүлэх, гадаадын хувьцаанд хөрөнгө оруулах боломжийг харилцагчдадаа олгох, цахим худалдааны салбарт эргэлтийн шинж чанартай ажлуудаа үргэлжлүүлж, Монголчуудын худалдан авалтын тогтсон хэв маягийг өөрчлөх хөдөлгөөнөө улам бүр идэвхжүүлэх болно. Лизинг, үл хөдлөх хөрөнгийн зах зээл рүү нэвтрэх оролдлогуудаа бид үргэлжлүүлэн лавшруулна.

Америкийн алдарт MGM продакшны бүтээл, 2004 оноос хойш АНУ, Их Британи, Ирланд зэрэг дэлхийн 24 улсад амжилттай зохион байгуулагдаж ирсэн The Apprentice бизнесийн реалити шоуг Монгол улсад Монгол HD телевиз албан ёсны эрхтэйгээр зохион байгуулахаар болсон ба уг шоу нэвтрүүлгийг Гүйцэтгэх захирал Ч. Ганхуяг шүүн явуулахаар боллоо. Монгол HD телевизийнхэн бол Got Talent, The Voice, Shark Tank зэрэг дэлхийн шилдэг контентыг монгол үзэгчдийн хүртээл болгож ирсэн туршлагатай хамт олон. Энэ бүтээлээр дамжуулж Ардыг олон нийтэд илүү сайн таниулах, Ардын бүтээгдэхүүн үйлчилгээг сонирхолтойгоор сурталчлах боломж гарлаа. Түүгээр зогсохгүй авьяас чадвартай манлайлагч залуусын хувьд Ард бол хүсэмжит ажил олгогч мөн гэдгийг энэхүү төсөл нотлох болно.

## Үнэлгээ

| (сая төгрөг)                       | 2018          | Эзэмшил | 2019          | Эзэмшил |
|------------------------------------|---------------|---------|---------------|---------|
| <b>Стратегийн хөрөнгө оруулалт</b> | <b>40,331</b> |         | <b>67,259</b> |         |
| Монгол Шуудан (MNP)                | 16,334        | 24.0%   | 18,066        | 25.5%   |
| Хөрөнгө Оруулагч Үндэстэн (JIV)    | 23            |         |               |         |
| Ард Даатгал (AIC)                  | 12,928        | 67.2%   | 13,356        | 66.8%   |
| Ард Кредит (ADB)                   | 5,028         | 80.7%   | 13,973        | 60.9%   |
| Ард Секюритиз                      | 2,305         | 100.0%  | 2,305         | 100.0%  |
| Ард Менежмент                      | 365           | 100.0%  | 365           | 100.0%  |
| Ард Актив                          | 48            | 9.9%    | 119           | 10.0%   |
| Ард Лайф                           | 2,426         | 100.0%  | 11,426        | 100.0%  |
| Ард Бит                            | 200           | 100.0%  | 200           | 100.0%  |
| ТэнГэр Системс                     | 674           | 100.0%  | 1,154         | 100.0%  |
| Ард Холдингс Интэрнэйшнл           |               |         | 6,295         |         |
| <b>Тактикийн хөрөнгө оруулалт</b>  | <b>3,480</b>  |         | <b>950</b>    |         |
| Номын Хишиг                        | 1,780         | 20.0%   | -             | 20.0%   |
| ТТДС                               | 750           | 12.4%   | -             | 4.0%    |
| КриптоҮндэстэн Сан                 | 950           | 32.4%   | 950           | 32.4%   |
| <b>Бусад</b>                       | <b>8,657</b>  |         | <b>-8,585</b> |         |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт   | 4,964         |         | 17            |         |
| Үндсэн хөрөнгө                     | 987           |         | 769           |         |
| Бэлэн мөнгө                        | 2             |         | 43            |         |
| Цэвэр авлага                       | 2,705         |         | -9,414        |         |
| <b>Нийт үнэлгээ</b>                | <b>52,468</b> |         | <b>59,624</b> |         |
| Эргэлтэд байгаа хувьцааны тоо      | 17,194,364    |         | 27,175,629    |         |
| <b>Нэгж хувьцааны үнэ</b>          | <b>3,051</b>  |         | <b>2,195</b>  |         |

## Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааны арилжаа



**52 долоо хоног (2019)**

₮1,200 - ₮2,300

**Нийт хувьцааны тоо**

28,614,263

**Зах зээлийн үнэлгээ**

₮50.53 тэрбум

**Нийт арилжааны дүн**

₮3.08 тэрбум

**Хаалтын үнэ**

₮1,766

**Дансны үнэ**

₮2,082

**P/E - Үнэ/Ашиг**

8.81

**P/B - Үнэ/Дансны үнэ**

0.85

## Хараат бус аудитын тайлан



### ХАРААТ БУС АУДИТОРЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

#### "АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

##### Дүгнэлт

Хураангуй санхүүгийн тайлан нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ээрх хураангуй санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлого үр дүн, бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас бүрдсэн.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хураангуй санхүүгийн тайлан нь бүхний л материаллаг зүйлсийн хувьд Аудитлагдсан Санхүүгийн Тайлан, түүний нэмэлт тодруулгатай тохирч байна.

##### Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС-ын) шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Сангийн сайдлын баталсан аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу илэрхийлэгдсэн аудитлагдсан санхүүгийн тайланг орлохгүй.

##### Аудитлагдсан санхүүгийн тайлан ба бидний дүгнэлт

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тус компанийн санхүүгийн тайланд хязгаарлалтгүй санал дүгнэлт өгсөн. Уг тайланд аудитын гол асуудлын талаарх мэдээллийг тусгасан. Аудитын гол асуудал нь бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн чухал асуудал байдаг.

##### Хураангуй тайлангийн талаар удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь эрх бүхий байгууллагын баталсан журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, түүндээ үндэслэн хураангуй санхүүгийн тайлангаа үнэн зөв бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

##### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Компанийн зүгээс бэлтгэсэн хураангуй санхүүгийн тайлан нь бүхний л материаллаг зүйлсийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байгаа эсэхийг шалгах, АОУС 810 буюу "Хураангуй санхүүгийн тайлангийн талаар тайлагнах гэрээт ажлууд"-аар шаардсан горимуудыг гүйцэтгэж дүгнэлт өгөх явдал юм.



2020 ОНЫ 03 ДУГААР  
САРЫН 25-НЫ ӨДӨР

## Санхүүгийн байдлын тайлан

| Үзүүлэлт                                              | 2019.12.31.<br>(мянган төгрөг) | 2018.12.31.<br>(мянган төгрөг) |
|-------------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| <b>ХӨРӨНГӨ</b>                                        |                                |                                |
| Эргэлтийн хөрөнгө                                     |                                |                                |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө                        | 43,235.60                      | 2,034.80                       |
| Худалдааны болон худалдааны бус авлага                | 4,902,640.10                   | 3,001,265.80                   |
| Бусдад олгосон зээл, зээлийн хүүний тооцоо            | 403,269.00                     | 6,820,414.50                   |
| Татвар, шимтгэлийн авлага                             | 6,864.80                       | 14,941.40                      |
| Бараа материал                                        | 6,231.10                       | 36,364.20                      |
| Урьдчилж төлсөн зардал                                | 3,685,467.00                   | 830,472.10                     |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт                      | <b>13,989,498.90</b>           | <b>146,055.70</b>              |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө |                                | 2,400,000.00                   |
| <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>                        | <b>23,037,206.50</b>           | <b>13,251,548.40</b>           |
| Эргэлтийн бус хөрөнгө                                 |                                |                                |
| Үндсэн хөрөнгө (цэвэр)                                | 642,006.70                     | 739,940.70                     |
| Биет бус хөрөнгө (цэвэр)                              | 127,431.20                     | 246,604.60                     |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт                         | 54,265,176.20                  | 43,810,718.80                  |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө     |                                | 2,417,832.10                   |
| <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>                    | <b>55,034,614.10</b>           | <b>47,215,096.20</b>           |
| <b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>                                   | <b>78,071,820.60</b>           | <b>60,466,644.60</b>           |

| Үзүүлэлт                                        | 2019.12.31.<br>(мянган төгрөг) | 2018.12.31.<br>(мянган төгрөг) |
|-------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| <b>ӨР ТӨЛБӨР</b>                                |                                |                                |
| Богино хугацаат өр төлбөр                       |                                |                                |
| Худалдааны болон худалдааны бус өр төлбөр       | 2,333,638.60                   | 131,267.00                     |
| Бусад өглөг                                     | 12,901.70                      | 12,675.80                      |
| Богино хугацаат зээл                            | 1,082,465.30                   | 1,814,620.00                   |
| Түрээсийн өрийн богино хугацаанд төлөгдөх хэсэг | 41,096.30                      |                                |
| Хүүний өглөг                                    | 198,315.50                     | 251,491.30                     |
| Татварын өглөг                                  | 68,822.00                      | 23,877.40                      |
| <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>         | <b>3,737,239.40</b>            | <b>2,233,931.50</b>            |
| Урт хугацаат өр төлбөр                          |                                |                                |
| Урт хугацаат зээл                               | 2,236,039.00                   | 240,370.20                     |
| Түрээсийн өр төлбөр                             | 261,389.70                     |                                |
| Бусад урт хугацаат өр төлбөр                    | 12,183,954.70                  | 5,524,671.10                   |
| Хойшлогдсон татварын өглөг                      | 3,070,863.00                   | 1,957,039.50                   |
| <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>            | <b>17,752,246.40</b>           | <b>7,722,080.80</b>            |
| <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                           | <b>21,489,485.80</b>           | <b>9,956,012.30</b>            |
| Өөрийн хөрөнгө                                  |                                |                                |
| Энгийн хувьцаа                                  | 28,590,335.00                  | 1,879,652.80                   |
| Халаасны хувьцаа                                | -1,414,706.00                  | -160,216.40                    |
| Нэмж төлөгдсөн капитал                          |                                | 9,929,060.70                   |
| Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц сан          | 16,124,512.70                  | 14,081,066.00                  |
| Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг                  | 13,799.10                      | 13,799.10                      |
| Хуримтлагдсан үр дүн                            | 13,268,394.00                  | 24,767,270.20                  |
| <b>НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>                      | <b>56,582,334.80</b>           | <b>50,510,632.40</b>           |
| <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>         | <b>78,071,820.60</b>           | <b>60,466,644.70</b>           |

## Орлого үр дүн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

| Үзүүлэлт                                          | 2019.12.31.<br>(мянган төгрөг) | 2018.12.31.<br>(мянган төгрөг) |
|---------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| Борлуулалтын орлого                               | 1,569,829.50                   | 3,863,044.90                   |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг                   |                                |                                |
| <b>Нийт ашиг</b>                                  | <b>1,569,829.50</b>            | <b>3,863,044.90</b>            |
| Хүүний орлого                                     | 304,891.30                     | 351,531.90                     |
| Ногдол ашгийн орлого                              | 537,156.70                     | 897,653.70                     |
| Бусад орлого                                      | 87,252.30                      | 296,165.60                     |
| Борлуулалт, маркетингийн зардал                   | (1,262,376.90)                 | (322,092.80)                   |
| Ерөнхий удирдлагын зардал                         | (4,441,981.10)                 | (3,209,382.00)                 |
| Хүүний зардал                                     | (1,454,685.70)                 | (854,143.20)                   |
| Бусад зардал                                      | (132,645.10)                   | (104,602.40)                   |
| Гадаад валютын ханшийн зөрүү олз (гарз)           | (20,035.50)                    | 54,643.70                      |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)        | (34,430.20)                    |                                |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)      |                                |                                |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)   | 163,761.10                     |                                |
| Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз(гарз)           | 9,059,062.80                   | (180,267.90)                   |
| <b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>             | <b>4,375,799.20</b>            | <b>792,551.60</b>              |
| Орлогын албан татварын зардал                     | (970,978.20)                   | (124,918.60)                   |
| <b>Тайлант жилийн татварын дараах ашиг</b>        | <b>3,404,821.00</b>            | <b>667,633.00</b>              |
| Бусад дэлгэрэнгүй орлого:                         |                                |                                |
| Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөцийн цэвэр өсөлт | 2,043,446.80                   | 6,730,845.00                   |
| Нийт дэлгэрэнгүй орлого                           | 5,448,267.80                   | 7,398,478.10                   |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг                  | 155.17                         | 38.83                          |

## Мөнгөн гүйлгээний тайлан

| Үзүүлэлт                                         | 2019.12.31.<br>(мянган төгрөг) | 2018.12.31.<br>(мянган төгрөг) |
|--------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| <b>1.Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>          |                                |                                |
| 1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого         | 307,609.90                     | 849,588.40                     |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого      |                                | 442,380.40                     |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого        |                                |                                |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө           |                                |                                |
| Буцаан авсан албан татвар                        |                                |                                |
| Татаас, санхүүжилтийн орлого                     |                                |                                |
| Бусад орлого                                     | 307,609.90                     | 407,208.00                     |
| <b>1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b> | <b>(4,294,615.90)</b>          | <b>(3,834,173.70)</b>          |
| Ажиллагсдад төлсөн мөнгө                         | (453,807.80)                   | (722,458.00)                   |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө     | (167,721.60)                   | (118,098.70)                   |
| Бараа материал худалдан авахад төлсөн            | (28,927.90)                    | (638,929.00)                   |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө                  | (369,112.20)                   | (859,013.40)                   |
| Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө     | (35,281.50)                    | (28,787.50)                    |
| Хүүний төлбөрт төлсөн                            | (1,345,981.80)                 | (660,395.80)                   |
| Татварын байгууллагад төлсөн                     | <b>(127,467.00)</b>            | <b>(162,124.00)</b>            |
| Даатгалын төлбөрт төлсөн мөнгө                   | (18,269.70)                    |                                |
| Бусад мөнгөн зарлага                             | (1,748,046.40)                 | (644,367.30)                   |
| <b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>      | <b>(3,987,006.00)</b>          | <b>(2,984,585.30)</b>          |

## Мөнгөн гүйлгээний тайлан

| Үзүүлэлт                                                     | 2019.12.31.<br>(мянган төгрөг) | 2018.12.31.<br>(мянган төгрөг) |
|--------------------------------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| <b>2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>   |                                |                                |
| Хүлээн авсан хүүний орлого                                   | 8,986.50                       | 84,575.00                      |
| Ногдол ашгийн орлого                                         | 485,721.60                     | 93,406.40                      |
| Бусдад олгосон зээл, урьдчилгааны буцаан төлөлт              | 3,555,791.90                   | 8,467.30                       |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого                             | 132,951.90                     |                                |
| Хөрөнгө оруулалт худалдсанаас орсон мөнгө                    | 497,756.60                     |                                |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө                    | (69,197.20)                    | (230,045.30)                   |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө                  | (11,027.10)                    | (6,180.30)                     |
| Бусдад олгосон зээл, урьдчилгаа                              | (4,151,021.90)                 | (622,520.70)                   |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө                  | (2,490,212.60)                 | (469,000.00)                   |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн              | (1,366,018.10)                 |                                |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ      | -3,406,268.40                  | -1,141,297.60                  |
| <b>3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>           |                                |                                |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан          | 8,468,672.80                   | 4,425,231.90                   |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө                 | (1,032,546.60)                 | (825,778.70)                   |
| Хувьцаа гаргалтын орлого                                     |                                |                                |
| Хувьцаа, өрийн үнэт цаас буцаан худалдаж авахад төлсөн мөнгө | (1,651.00)                     | (160,601.90)                   |
| Бусад санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого               |                                |                                |
| <b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>       | <b>7,434,475.20</b>            | <b>3,438,851.30</b>            |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ                                     | 41,200.80                      | (687,031.60)                   |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл              | 2,034.80                       | 689,066.40                     |
| <b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>      | <b>43,235.60</b>               | <b>2,034.80</b>                |





Хүчтэй. Хамтдаа.